# АШИГЛАЛТААС ГАРСАН ХАР ТУГАЛГАН ХҮХРИЙН ХҮЧЛЭН БАТАРЕЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ТЕХНОЛОГИ АШИГЛАН ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

# 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: 0000025/
/РЕГИСТРИЙН ДУГААР: 6352901/

**ХЯНАСАН**:

БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА /А.ЭНХБАТ/

БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН /П.ШИНЭЦЭЦЭГ/

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /Ө.ОДОНСҮРЭН/

“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК-ИЙН ХЭМАББО ИНЖЕНЕР /Э.ОЮУНТУЯА/

**2025 ОН**

**Агуулга**

1. Оршил ..... 5
2. Төслийн товч танилцуулга ..... 6
2.2. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт ..... 6
2.3. Төслийн байршил ..... 7
2.4. Үйлдвэрийн танилцуулга ..... 8
3. Байгаль орчин, төлөв байдлын товч тодорхойлолт ..... 9
3.1. Цаг уур, уур амьсгалын төлөв байдал ..... 9
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ..... 12
4.1. Байгаль орчны менежмийн тогтолцооны хүрээнд: ..... 12
4.2 Агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ ..... 15
4.3 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал, үнэлгээ ..... 17
4.4 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ ..... 17
4.5 Усан орчинд нөлөөлөх байдал, үнэлгээ ..... 19
4.6 Хог хаягдлын менежмент ..... 19
5. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ..... 20
5.1 Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөлтийн биелэлт ..... 25
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 28
6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ..... 28
6.2 Цаг уур, уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ..... 32
6.3 Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ..... 34
6.4 Усны чанар, найрлагад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ..... 36
..... 37
6.5 Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ..... 39
6.6 Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр ..... 40
7.Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт ..... 42
8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 44
8.1 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 44
8.2 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт ..... 44
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 44
9. Орчны шинжилгээний хөтөлбөр -2025 он ..... 48
10.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ..... 50
11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардлын нэгдсэн дүн ..... 51

**Хүснэгтийн жагсаалт**

*Хүснэгт 1. Үйлдвэрийн бүсийн булангийн цэгийн солбилцол ..... 7*
*Хүснэгт 2. Үр дагавар (Хохирол) ..... 12*
*Хүснэгт 3. Магадлал ..... 13*
*Хүснэгт 4. Асуудал, нөлөөллийн үнэлгээний матриц ..... 13*
*Хүснэгт 5. Хяналтын шатлал ..... 14*
*Хүснэгт 6. Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6342-2016) ..... 16*
*Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл ..... 18*
*Хүснэгт 8. Усан орчинд үзүүлж болзошүй сөрөг нөлөөлөл ..... 19*
*Хүснэгт 9. Хог хаягдлын менежмент, болзошгүй сөрөг нөлөөлөл ..... 19*
*Хүснэгт 10. Агаарын чанарын бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 28*
*Хүснэгт 11. Цаг уур, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 32*
*Хүснэгт 12. Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөөгний биелэлт ..... 34*
*Хүснэгт 13. Усны чанар, найрлагад нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 36*
*Хүснэгт 14. Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..... 39*
*Хүснэгт 15. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 40*
*Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 44*
*Хүснэгт 17. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ..... 48*
*Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд ..... 50*
*Хүснэгт 19. Зардлын нэгдсэн дүн ..... 51*

***Зургийн жагсаалт***

*Зураг 1. “Электрокем Монгол” ХХК-ийн дахин боловсруулах үйлдвэрийн байрзүйн зураг ..... 7*
*Зураг 2. Аж ахуй нэгжид газар ашиглуулах гэрээ ..... 8*
*Зураг 3. Паркт үйл ажиллагаа явуулах гэрээ ..... 8*
*Зураг 4. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд ..... 9*
*Зураг 5. Байгаль орчны асуудал, нөлөөллийн үнэлгээ, эрсдэл боломжид чиглүүлэн авах арга хэмжээ ..... 12*
*Зураг 6. Байгаль орчны хяналтын арга хэмжээний хүрээнд батлагдсан журам, зааврууд ..... 15*
*Зураг 7. Харуулын байрыг шийдсэн байдал ..... 17*
*Зураг 8.Үйлдвэрийн бүсэд хайрган хучилттай зам талбай тохижуулсан байдал ..... 18*
*Зураг 9. Сургалт зохион байгуулсан талаар ..... 22*
*Зураг 10. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал унтраах тактикийн сургалт ..... 24*
*Зураг 11. Галын аюулгүй байдлын дүгнэлт, сургалтын төлөвлөгөө ..... 24*
*Зураг 12. Галын хэрэгсэл байршуулсан байдал ..... 25*

*Зураг 13. Анхны тусламжийн өрөөг тохижуулсан байдал ..... 26*
*Зураг 14. Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалт ..... 27*
*Зураг 15. Тэмдэг тэмдэглэгээ, нүд угаах цэг байршуулсан байдал ..... 28*
*Зураг 16. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр төлсөн баримт ..... 28*
*Зураг 17. Хор аюулын лавлан мэдээлэл ..... 31*
*Зураг 18. Химийн бодисын ашиглалтын бүртгэл ..... 31*
*Зураг 19. Үйлдвэрт хаягдал аккумлятор, Химийн агуулахад химийн бодис хураасан байдал ..... 33*
*Зураг 20. Үйлдвэр болон Химийн агуулахад үзлэг хийсэн тэмдэглэл ..... 33*
*Зураг 21. Асгаралтын иж бүрдлийг байршуулсан байдал ..... 35*
*Зураг 22. Асгаралтын хариу арга хэмжээний журам ..... 35*
*Зураг 23. Гүний худгийн зөвшөөрөл, тоолуурын гэрчилгээ ..... 38*
*Зураг 24. Үйлдвэр дотор гүний худгийн харагдах байдал ..... 38*
*Зураг 25. Үйлдвэрийн доторх худганд худаг гаргах зөвшөөрөл авч, худгийн пасспортыг баталгаажуулсан байдал ..... 39*
*Зураг 26. Усны газарт ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах хүсэлт болон усны торгууль төлсөн баримт ..... 39*
*Зураг 27. Мод тарьж буй байдал ..... 43*
*Зураг 28. Үйлдвэрийн ахуйн хог ачуулсан нэхэмжлэх болон төлбөр төлсөн баримт ..... 46*
*Зураг 29. Ахуйн бохир ус соруулуулсан төлбөрийн баримт ..... 47*
*Зураг 30.Бохир ус соруулах гэрээ ..... 47*
*Зураг 31. Химийн бодисын сав баглаа, боодол устгуулсан баримт ..... 48*
*Зураг 32. Агаар, ус, хөрсний шинжилгээний үр дүн ..... 50*
*Зураг 33. Усны торгууль төлсөн баримт ..... 52*
*Зураг 34. Торгууль төлсөн баримт ..... 53*

## 1. Оршил

Дэлхий нийтээр ашиглалтаас гарсан хар тугалгат хүхрийн хүчлэн батарей нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд өндөр эрсдэл учруулдаг аюултай хог хаягдлын нэгэнд тооцогддог. Хар тугалга болон хүхрийн хүчил нь хөрс, ус, агаарыг бохирдуулах, улмаар хүн, амьтан, ургамлын эрүүл мэндэд ноцтой сөрөг үр дагавар үзүүлэх Монгол орны хувьд хар тугалгын бохирдол нь агаарын бохирдлын дараа орох тулгамдсан асуудал болж байна. Хар тугалга болон хүхрийн хүчил нь хөрс, ус, агаарыг бохирдуулах улмаар хүн, амьтан, ургамлын эрүүл мэндэд ноцтой сөрөг үр дагавар үзүүлэх аюултай. Жилд дунджаар 500 мянга гаруй батарей хаягддаг бөгөөд хар тугалгын бохирдол нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 500-600 дахин их гэсэн судалгаа байдаг. Иймд ашиглалтаас гарсан хар тугалган батарейг аюулгүй цуглуулах, хадгалах, тээвэрлэх, байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага гарч байна.

“Электрокем Монгол” ХХК нь 2018 онд байгуулагдсан, 100 хувь дотоодын хөрөнгө оруулалттай компани бөгөөд ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батерейг олон улсын жишигт нийцсэн технологиор дахин боловсруулах, улмаар хар тугалга болон бусад түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркт байрладаг бөгөөд жилдээ ойролцоогоор 5,000 тонн буюу 300,000 ширхэг хар тугалгат батерей дахин боловсруулах хүчин чадалтайгаар төлөвлөгдөн ажиллаж байна.

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан нь үйлдвэрийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх боломжит нөлөөллийг тодорхойлох, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Тайланг боловсруулахдаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам болон олон улсын сайн туршлагыг баримталсан болно.

Үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд хаягдлын менежмент, бохирдлыг бууруулах арга хэмжээ, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, орчны чанарын хяналт-шинжилгээ хийх зэрэг чиглэлүүдийг энэхүү төлөвлөгөөнд тусгаж, тогтвортой үйлдвэрлэлийн зарчмыг хэрэгжүүлэхийг зорьсон.

# 2. Төслийн товч танилцуулга

## 2.1. Төслийн тодорхойлолт

| | |
|---|---|
| 2.1.1. Төслийн нэр | Хар тугалгат – хүчлийн батарейг байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулж, барилгын материал үйлдвэр |
| 2.1.2. Төслийн байршил | Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Налайхын үйлдвэр технологийн парк, Баян 12614 тоот |
| 2.1.3. Төсөл хэрэгжүүлэгч | “Электрокем Монгол” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011756132, Регистрийн дугаар: 6352901 |
| 2.1.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Ханну төв – 203 тоот Утас: 99114175, 77229999 |

## 2.2. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт

“Электрокем Монгол” ХХК дахин боловсруулах үйлдвэр нь жилд 5000 тн хаягдал батарей дахин боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ажиллах ба жилд 2900 тн хар тугалган бүтээгдэхүүн, 200-300 тн гөлтгөнө үйлдвэрлэнэ. Эхний жилд 2500 тн хаягдал батарейг дахин боловсруулж 1450 тн хар тугалган бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх бол үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт аажмаар нэмэгдэж 5 дахь жилд 4500 тн хаягдал батарей боловсруулж, 2600 тн хар тугалган бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үйлдвэрлэсэн гөлтгөнийг 100 хувь цементийн дотоодын үйлдвэрүүдэд, хар тугалган бүтээгдэхүүний 20 орчим хувийг дотоодын зах зээлд, үлдэгдэл 80 орчим хувийг БНХАУ болон БНСУ-ын зах зээлд борлуулахаар төлөвлөсөн. Мөн үйлдвэрийн хүчин чадлаа бүрэн ашиглаж эхэлсэн нөхцөлд 350 орчим тн угааж цэвэрлэсэн хуванцар дайвар бүтээгдэхүүнийг гарган авахаар төлөвлөн ажиллаж байна.

Хаягдал батарейг дахин боловсруулах үйлдвэрийн онцлог, холбогдох стандартын дагуу тавигдаж байгаа шаардлагууд болон хаягдал батарейг тээвэрлэх болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэргийг харгалзан үзэж үйлдвэрийг “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк“-ийг түшиглэн байгуулсан. Дахин боловсруулах үйлдвэр нь үйлдвэрийн үндсэн байр, хаягдал батарейг түр хадгалах агуулах, үйлдвэрээс гарах хорт утааг цэвэршүүлэх систем, хар тугалган бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех, хүчил саармагжуулах цех, эцсийн бүтээгдэхүүнийг хадгалах агуулах байгаа бол үлдсэн хэсэгт үйлдвэрийн захиргаа оффисын барилга болон ажилчдын амрах байр, химийн агуулах зэргээс бүрдэж байна.

Хаягдал батарейг дахин боловсруулах үйлдвэрт нийтдээ 34 ажилчид ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд эдгээрт үйлдвэрийн дарга, ээлжийн ахлагч, үйлдвэрийн оператор болон туслах ажилчид, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын ажилтан, байгаль орчны мэргэжилтэн, хог хаягдлын мэргэжилтэн зэрэг орон тоо багтаж байна. Ажлын цаг нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу 1 ээлжид 8 цаг, жилд 250 хоног ажиллана.

## 2.3. Төслийн байршил

Үйлдвэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороо, Баян /12614/ гудамж, 114/1 тоот хаягт байрладаг бөгөөд Улаанбаатар хотоос 55 км, Налайх дүүргээс урагш 10 км зайд байрлана.




*Зураг 1. “Электрокем Монгол” ХХК-ийн дахин боловсруулах үйлдвэрийн байрзүйн зураг.*

“Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” ХК-ийн эзэмшлийн 4.0 га талбайд 2023 оны 12-р сарын 01-ний өдрийн №2023/29 тоот дугаартай “Аж ахуй нэгжид газар ашиглуулах” гэрээ болон №23/29 тоот дугаартай “Паркт үйл ажиллагаа явуулах” гэрээний дагуу Налайх Дүүргийн Үйлдвэрлэл, Технологийн паркийн нэгж болон ажиллаж байна.

*Хүснэгт 1. Үйлдвэрийн бүсийн булангийн цэгийн солбилцол*

| Зориулалт | Талбайн хэмжээ /м²/ | Цэгийн дугаар | Солбицол | | Цэгүүд |
|---|---|---|---|---|---|
| | | | X | Y | |
| Хаягдал аккумлятор боловсруулах үйлдвэр | 40933.0 | 1 | 5287375.328 | 669409.469 | 1-2 |
| | | 2 | 5287498.452 | 669409.207 | 2-3 |
| | | 3 | 5287498.294 | 669421.233 | 3-4 |
| | | 4 | 5287570.395 | 669420.857 | 4-5 |
| | | 5 | 5287570.190 | 669521.132 | 5-6 |
| | | 6 | 5287570.190 | 669623.970 | 7-8 |
| | | 7 | 5287570.709 | 669623.970 | 8-9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8 | 5287570.709 | 669521.132 | 9-1 |



*Зураг 2. Аж ахуй нэгжид газар ашиглуулах гэрээ*



*Зураг 3. Паркт үйл ажиллагаа явуулах гэрээ*

## 2.4. Үйлдвэрийн танилцуулга

“Электрокем Монгол” ХХК-ийн хар тугалгат - хүхрийн хүчлийн батарейг байгальд ээлтэй технологиор дахин боловсруулж, гарсан түүхий эд материалаар барилгын материал үйлдвэрлэх зорилгоор 2024 оны 03 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү төслийн хүрээнд дараах барилгын материалуудыг үйлдвэрлэнэ. Үүнд:

1. Батарейны хүхрийн хүчлийн уусмалыг цэвэршүүлэн саармагжуулж, цемент үйлдвэрлэлийн гол түүхий эд болох гипс буюу гөлтгөнө үйлдвэрлэх, улмаар гипсэн хавтан үйлдвэрлэх
2. Хар тугалган хавтан, хуулга, ялтас (дээвэр, дээврийн ам дарагч, усны хаялга, парпетны малгай, бетон суурийг хөрснөөс тусгаарлагч)
3. Хар тугалган тоосго (рентген туяанаас тусгаарлагч хана)
4. Замын хавтан зэрэг болно.

Үйлдвэрийн үйл ажиллагааг дараахи эрх бүхий тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулж байна.

1. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөл, /0000033 дугаартай 5 жилийн хугацаатай/
2. Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, / 0002614 дугаартай 5 жилийн хугацаатай/
3. Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл /2022.07.04-2028.09.19/


АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2024.04.25


ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2024.01.10


ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН
ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025.09.23

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл**

Регистрийн дугаар : **6352901**
Нэр : **ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ Хязгаарлагдмал хариуцлагатай компани**

**Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл**

Авсан огноо : **2022-07-04**
Дуусах огноо : **2028-09-19**
Хүчинтэй эсэх : **Хүчинтэй**
Тусгай зөвшөөрлийн нэр : **ТӨМӨРЛӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

*Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу*

Зураг 4. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд

## 3. Байгаль орчин, төлөв байдлын товч тодорхойлолт

### 3.1. Цаг уур, уур амьсгалын төлөв байдал

Налайх дүүрэг нь нийслэлээс зүүн урагш 36 км-т, өвөлдөө -20℃ -25℃, зундаа +23℃ +26℃ хэмийн дундаж температуртай ойт хээрийн бүсэд оршдог. Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй, атмосферийн тунадасны хэлбэлзэл120-220 мм бөгөөд жилийн дунджаар 200 мм хүрдэг.

Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр орох жишээтэй байдаг. Хамгийн халуун үе 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард болдог. Хамгийн их хур тунадас унадаг улирал нь зун байна. Өвөл хөрс нь 3-5 м гүн хөлддөг.

Энэ орчинд салхины тооцооны их хурд жил бүрд 20 м/с, 5 жилд 23 м/с, 20 жилд 28 м/с тус тус хүрч 5 жилд тохиолдох их хурдаар бодож тооцон үнэлбэл салхины шахац /ачаалал/ 35-

40 кг/м2 даралттай үйлчилдэг. Заримдаа салхины их хурднаас шалтгаалан салхины ачаалал түр зуур үүнээс өндөрсөж ихэсдэг онцлогтой.

Цэвдэгшилт нилээд тархалттай бөгөөд газрын тогтоц, чулуулгийн литологийн бүтцээс хамаарч нам дор газар 1.5-2.0 м, өндөрлөг хэсэгт 3.5- 5.0 м-т тохиолдоно. Ордын дүүрэг нь газар хөдлөлтийн VII-VIII бүсэд хамаарна.

### 3.2. Агаарын чанарын төлөв байдал

Төсөл хэрэгжих талбай орчимд агаар бохирдуулах эх үүсвэр байхгүй бөгөөд төсөл хэрэгжих талбайн хэмжээнд нутаг дэвсгэрийн дуу чимээний түвшин үндсэндээ хөдөө нутгийн байгалийн өөрийнх нь түвшнийг илэрхийлнэ. Дуу чимээний үүсэх, тархах онцлог нь байгаль, цаг уур, гадаргын байдлаас ихээхэн хамаарах ба хүлээн авагчид мэдрэгдэх байдлаараа тодорхой түвшнээс их болсон үед шуугиан болж тодорхойлогддог.

### 3.3. Усан орчны төлөв байдал

Үйлдвэрийн талбай орчим нь жилд орох хур тунадасны хэмжээ дунд зэрэг бөгөөд гадаргын усны хувьд байнгын тогтмол нуургүй, ихэвчлэн хур борооны усаар тэжээгддэг цөөн тооны булаг, шандтай. Гадаргын усны нийт нөөц 0,01 км куб/жил, үүнээс ашиглаж болох нөөц тогтоогдоогүй, газрын доорх усны нөөц 0,25 км куб/жил үүнээс ашиглаж болох нөөц 0,12 км куб/жил гэж тогтоогдсон. Тогтмол урсгал усгүй. Тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч нуур тойром, худгийн усны түвшин өөрчлөгдөнө. Тус район нь газрын доорх усны нөхцөлөөр ундарга нь 5-10 мм/жил байдаг бөгөөд газрын доорх усны ундарга нь төвөгтэй нөхцөлтэй бүлэгт хамаардаг байна.

Тус үйлдвэр нь гүний худаг гаргаж үйлдвэрийн технологийн болон ахуйн хэрэглээний усыг хангахаар төлөвлөсөний дагуу 2023 онд холбогдох зөвшөөрлийг авч “Эрдэнэ дриллинг” ХХК-тай гэрээ байгуулан 2ш гүний худаг гаргуулсан болно. Уг гүний худгаас дээж авч нян судлалын лабораторид өгсөн ба шинтжлгээний хариу нь холбогдох сатандартыг хангасан болно.

### 3.4. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Үйлдвэрийн талбай нь газрын гадаргуу ерөнхийдөө тэгшивтэр бөгөөд долгиотсон бичил гадаргуу зонхилно. Налайх орчмын нутаг дэвсгэр Хөрс-газарзүйн мужлалтаар Төв Азийн их мужийн Хангайн мужийн өндрийн бүсшилийн Хангай-Хэнтийн дэд мужийн өмнөдийн 53 дугаар тойрогт хамрагдана.

Энэхүү тойрогт хамрагдсан нутагт уулын нугат хээрийн, уулын ойн ширэгт бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн, тал хөндийн хар хүрэн, нугат хар хүрэн, ердийн хүрэн хөрс тус тус тархана. Налайхын төвийн суурьшлын бүсээс гадагш хуурай хээрийн ургамал зонхилж, уулсын хажуу бэлээр сайр чулуурхаг хүрэн хөрс, нам хотос хөндийн хэсгээр нугат хар хүрэн, Налайхын гол, Бүст нуурын орчмоор нугын болон намгийн ширэгт хөрс, хужир мараалаг хөрс тархаж нэлээд талбайг эзэлнэ.

Газрын гадаргын төрх байдал, зүг зовхисын ялгаа, гадаргын налуу, хөрс үүсгэгч эх чулуулаг, ургамал нөмрөгийн хэв шинжээс хамаарч хэд хэдэн төрлүүдээр илрэх ба хөрс бүрийн морфологи тогтцын онцлог, физик - химийн голлох үзүүлэлтүүдээс хамаарч хөрсний үржил шимийн ерөнхий түвшин харилцан адилгүй байна. Төсөл хэрэгжих талбай нь хөрсөн бүрхэвч нь хүний үйл ажиллагаанд өртөөгүй, байгалийн унаган төрхөөрөө байгаа газар нутаг юм.

### 3.5. Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Монгол орны ургамал-газар зүйн мужлалаар Налайх орчмын нутгийг Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамааруулдаг (Өлзийхутаг, 1989) боловч энэ нутаг Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрог ба Дундад Халхын хуурай хээрийн тойргийн зааг дээр оршдог учраас уулын хээр ба жинхэнэ хээрийн хэвшлийн ургамалжилтыг хосолсон шинж чанартай байна. Тухайлбал, шивээт хялгана хазаарганат (Stipa + kryllovi + Cleistogenes squarrosa), шивээт хялгана-хазааргана-элдэв өвст хээрийн хэвшлүүд зонхилно. Зарим хотгор газраар шивээт хялгана-ширэг өлөнт (Stipa Cryllovi + Carex duriuscula), шивээт хялгана-Нангиад түнгэт хуурай хээр тохиолддог явдал Дундад Халхын тойргийн хэвшил нөлөөлснийг харуулж байна. Толгодын энгэр өврийн чулуурхаг хэсгээр шивээт хялгана-агь-шавагт (Stipa Cryllovi +Artemisia fiigada +Artemisia adamsii) болон хялгана бүхий ерхөгт (Agropyron cristatum) хэвшил бүрэлдсэн.

Үйлдвэр байгуулсан газрын байрлал нь хотгор, дов, хөндий хосолсон гадаргуутай. Ийм байрлалд ноёлох салхины чиг өвөл зунаар эсрэг тэсрэг байх магадлалтай. Төсөл хэрэгжих талбай орчмоор шивээт хялгана, дааган сүүл-агитай хувилбар, аги бүхий морины ботуул, цахилгана, хөндийгөөр ширгийн улалж, зүлгийн улалж, цахилдаг, түнхэ зонхилно.

Төсөл хэрэгжих талбай болон түүний нөлөөллийн бүсэд хоёр төрлийн ургамалжилт тархсан бөгөөд дийлэнх хувийг хээрийн ургамалжилт эзэлнэ.

1. Хээрийн ургамалжилт – нугажуу хээр, дундаж өндөр ба нам уулсын хялганат, буур өвст, биелэг өвст (Stipa baicalensis, Festuca sibirica, Poa attenuate, Filifolium sibiricum), хянганд хусан төгөл, алаг өвст

2. Татмын ургамалжилт – бургаст (Salix kochiana, S.viminalis), сорвоот (Calamagrostis purpureum), улалжит (Carex cespitosa, C.ortostachys) намаг, алаг өвст (Thalictrum simplex) нуга зэрэг болно.

### 3.6. Амьтны аймгийн төлөв байдал

Налайх орчмын нутаг бол манай орны хээрийн бүсийн хойд хэсэгт багтана. Хэдийгээр хээрийн бүсэд багтаж байгаа боловч ойт хээр, ойн бүстэй ойр зэргэлдээ оршиж байгаа учраас ойт хээр болон ойд тохиолддог зарим амьтад хааяа тохиолдоно.

Бүс нуур болон Налайх хотгор түүний татам дагуух жижиг цөөрөм, нуга, намгаар ус намгийн шувууд нилээд амьдардаг. Ус намгийн шувуудын ихэнх нь хавар, зуны улиралд цугларч, зарим нь тэр орчимд өндөглөн зусдаг нүүдлийн шувууд юм. Тухайлбал: Бүс нуурт ангир /Tadorna ferruginea/, зэрлэг нугас /Anas piatyrhynchos/, хумхин нугас /Mergus merganser/, голын хараалай /Sterna hirunda/, мөнгөлөг цахлай /Larus argentatus/ гэсэн 5 зүйл усны шувуу байх ба нэг удаагийн тооллогоор 46 бодгаль ангир, 9 бодгаль зэрлэг нугас, 16 бодгаль мөнгөлөг цахлай тохиолдож байсан мэдээ байдаг.

Төслийн талбайн орчинд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (P.domesticus) ба хээрийн (P.montanus) бор шувуу, хөхвөр тагтаа (C. livia), сохор элээ (Milvus migrans), шаазгай (Pica pica), улаан хошуут (Pyrrhcorax pyrrhocorax), хар хэрээ (Corvus corone), хон хэрээ (Corvus corax) зэрэг шувууд арай олон үзэгдэж байна. Хөхтний дотроос хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог таарaлдана.

## 4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Энэ бүлгийн зорилго нь Налайх дүүргийн 3-р хороонд байрлах “Электрокем Монгол” ХХК-ийн “Хар тугалган-хүчлийн батарей дахин боловсруулах үйлдвэр” -ийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлж, дүн шинжилгээ хийж, тодорхойлон тооцоход оршино.

### 4.1. Байгаль орчны менежмийн тогтолцооны хүрээнд:

ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоог үйлдвэрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж стандартын дагуу байгаль орчинд нөлөөлж болох асуудал, аюулыг илрүүлэх, нөлөөлөл, эрсдлийг үнэлэх, хяналт тогтоох, түүнээс үүсч болох сөрөг нөлөөлөл, үр дагаврыг хамгийн бага түвшинд байлгах, бууруулах зорилгоор **“4-Ж-1.0.2 Байгаль орчны асуудал нөлөөллийн үнэлгээ”-**г хийсэн.



*Зураг 5. Байгаль орчны асуудал, нөлөөллийн үнэлгээ, эрсдэл боломжид чиглүүлэн авах арга хэмжээ*

Асуудал нөлөөллийг тодорхойлсны дараа түүнээс гарч болох үр дагавар (хохирол), магадлал болон нөлөөлөл, эрсдлийн зэргийг тогтооно. Үр дагаврын хэмжээг дараах зэрэглэлд хуваана. Үүнд:

*Хүснэгт 2. Үр дагавар (Хохирол)*

| ХОХИРОЛ/ҮР ДАГАВАР |
|---|

| Түвшин | Гэмтлийн хэмжээ | Байгаль орчны хохирол |
|---|---|---|
| **1 (Маш бага)** | Эмчилгээ болон анхны тусламж шаардлагагүй жижиг гэмтэл | Арга хэмжээ авах шаардлагагүй, үл ялиг нөлөө үзүүлсэн тул уугуул төрхнөөс ялгагдахгүй. |
| **2 (Бага)** | Анхны тусламж авах, ажилтныг түр хугацаагаар таагүй байдалд оруулах гэмтэл | Байгаль орчинд багахан хэмжээний засаж болохуйц нөлөө үзүүлсэн. (Үүнийг заавал нэн даруй засах нөхцөл үүсээгүй) (< $5K) |
| **3 (Дунд)** | Эмнэлгийн мэргэжлийн тусламж шаардагдах тохиолдол – Хөнгөн ажилд шилжүүлэх | Хэсэг газарт хохирол учруулсан эсхүл лицензийн нөхцөлөөс давсан үйл ажиллагаа явуулсан.<br>Засах зардал ($5K - $20K) |
| **4 (Их)** | Амь насанд аюулгүй ч эмнэлэгт хэвтүүлж эмчлэх шаардлагатай хүнд гэмтэл, өвчин<br>(хөдөлмөрийн чадвар түр алдалт) | Уугуул нутгийн ургамал, амьтны аймагт хор хөнөөл үзүүлсэн эсхүл хууль зөрчиж зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж БО-ыг доройтуулсан.<br>Сэргээх зардал ($20K - $50K) |
| **5 (Ноцтой)** | Амь насанд аюултай, бэртэл гэмтэлд олон хүн өртөх, нас баралт | Нөхөн сэргээх боломжгүй. БО-нд ноцтой эсхүл маш өргөн хүрээг хамарсан хохирол үүсч БО-ыг сүйтгэж, хууль тогтоомж зөрчсөн. Зардал (> $50K) |

Асуудал, аюул нь ажилтанд нөлөөлж бэртэл, гэмтэлд хүргэх болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал, давтагдах боломжийг тогтооно. Нөлөөлөл, эрсдлийн үнэлгээний баг нь тухайн асуудал, аюулыг ямар магадлал, давтамжтайгаар үүсч болохыг дараах байдлаар тодорхойлно.

*Хүснэгт 3. Магадлал*

| МАГАДЛАЛ (Тухайн асуудал, аюул үүсэх боломж, давтамж) | | |
|---|---|---|
| **Зэрэглэл** | **Тайлбар** | **Жишээ** |
| **A** | **Бараг байнга** – Нийтлэг / Үргэлж илэрдэг тохиолдол | Сардаа 1-ээс олон удаа тохиолдох |
| **B** | **Элбэг** – Байнга биш ч тохиолдох магадлал өндөр | Жилдээ 1-ээс олон удаа |
| **C** | **Боломжтой** – Тохиолдож болох юм “Би ийм зүйл болсон гэдгийг сонссон” гэх тохиолдол | 2-5 жилд 1-с дээш удаа |
| **D** | **Хааяа** – Элбэг тохиолдохгүй | 2-5 жилд 1 удаа |
| **E** | **Ховор** – Магадлал маш бага, бараг тохиолддоггүй | 6 жилээс дээш хугацаанд 1 удаа |

Асуудал, аюулаас үүдэн гарч болох үр дагавар (хохирол, нөлөө) болон тухайн аюул үүсч болох магадлал, давтамжийг харьцуулан үнэлэн нөлөөлөл, эрсдэлийн зэргийг дараах хүснэгтийн дагуу тогтооно.

*Хүснэгт 4. Асуудал, нөлөөллийн үнэлгээний матриц*

| | ХОХИРОЛ/ҮР ДАГАВАР | ЭРСДЭЛИЙН ЗЭРЭГ |
|---|---|---|

| **МАГАДЛАЛ** | 1-Маш Бага | 2-Бага | 3-Дунд | 4-Их | 5-Ноцтой | **Зэрэглэл** | Арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| А-Бараг байнга | **M (11)** | **H (16)** | **H (20)** | **VH (23)** | **VH (25)** | **VH23-VH25** | **Хэт Аюултай:** Ажлаа зогсоо. Нөлөөлөл, эрсдэлийг удирдах арга хэмжээг яаралтай ав. |
| B-Элбэг | **M (7)** | **M (12)** | **H (17)** | **H (21)** | **VH (24)** | **H16 – H22** | **Асуудал:** Нөлөөлөл, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. |
| C-Боломжтой | **L (4)** | **M (8)** | **M (13)** | **H (18)** | **H (22)** | **M7 - M15** | **Хяналт тогтоо:** Их зардал гарахааргүй бол арга хэмжээ авах нь зүйтэй. |
| D-Хааяа | **L (2)** | **L (5)** | **M (9)** | **M (14)** | **H (19)** | **L1 – L6** | **Хэвийн:** Тогтсон журмын дагуу ажилла. |
| E-Ховор | **L (1)** | **L (3)** | **L (6)** | **M (10)** | **M (15)** | | |

Нөлөөлөл эрсдэлийн зэргийг тодорхойлсны дараа арилгах, бууруулах, хяналтын арга хэмжээг дараах шатлалаар хэрэгжүүлнэ.

*Хүснэгт 5. Хяналтын шатлал*

| **ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ – Хяналтын арга хэмжээг дангаар нь болон хослуулан хэрэглэж болно.** | | | |
|---|---|---|---|
| **Хяналтын арга** | | **Түвшин** | |
| 1 | **АРИЛГАХ** – Асуудал, аюулыг бүрэн арилгах | **АРИЛГАХ** – Асуудал, аюулыг бүрэн арилгаж, орлуулж ажилтанд нөлөө үзүүлэх боломжгүй болгох арга | **Үр нөлөө сайтай** |
| 2 | **ОРЛУУЛАХ** – Асуудал, аюул багатай материал, үйл явцаар орлуулах | | |
| 3 | **ИНЖЕНЕРЧЛЭЛ** – Тоног төхөөрөмж эсвэл үйл явцыг дахин загварчлах<br>**ТУСГААРЛАХ** – Асуудал, аюулыг хааж эсвэл хамгаалалт хийж тусгаарлах | **ТУСГААРЛАХ** – Асуудал, аюулыг тусгаарлан хаалт хашилт хийх арга | |
| 4 | **ЗАХИРГАА, УДИРДЛАГА** – Сургалт, журам, тэмдэглэгээ зэрэг хяналтын арга хэрэгжүүлэх | **БУУРУУЛАХ** – Сургалт хийх, хяналт, үзлэг хийх, хамгаалах хэрэгсэл ашиглах, бодлого журам болон заавраар зохицуулах, тэмдэг тэмдэглээ тавих зэрэг аюулын үр дагаварыг бууруулах арга | **Үр нөлөө багатай** |
| 5 | **НБХХ** – Бусад арга хэмжээ авах тохиромжгүй үед нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглах | | |

**"4-Ж-1.0.2 Байгаль орчны асуудал нөлөөллийн үнэлгээ" –** г үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаа, түүхий эд цуглуулалтаас эцсийн бүтээгдэхүүн гарах хүртэлх бүх шат дамжлага, процесс, цех нэгжүүдэд хийж гүйцэтгэсэн. Үнэлгээгээр илэрсэн аюул, байгаль орчны тодорхойлсон асуудал нь ажлыг аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхээргүй гүйцэтгэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бичиг баримтуудыг боловсруулан гаргасан.

"Электрокем Монгол" ХХК нь аливаа аюул эрсдэл , байгаль орчны асуудлыг арилгах, бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл боломжид чиглүүлэн авах арга хэмжээг төлөвлөн төрөл бүрийн хяналтын арга болон стандарт заавар, журам боловсруулан хэрэгжүүлж, түүнийг мөрдөн ажиллаж байна. Эдгээрээс дурьдвал:

1. 4-Ж-1 Эрсдлийн удирдлагын журам
2. 4-Ж-5 ХЭМАББО-ны хяналтын журам
3. 4-Ж-6 Онцгой байдалд бэлэн байх, хариу арга хэмжээний журам
4. 4-Ж-16 Химийн бодисийн удирдлага, зохицуулалтын журам
5. 4-Ж-22 Байгаль орчны бохирдлын хяналтын журам
6. 4-Ж-23 Хог хаягдлыг удирдлагын процессийн журам
7. 4-Ж-24 Байгалийн нөөц ашиглалты журам
8. 4-Ж-28 Асгаралтын хариу арга хэмжээний журам
9. Үйл ажиллагааны стандарт зааврууд
10. Гүйцэтгэлийн мониторинг, шинжилгээний хөтөлбөр
11. 5-С-010 ХЭМАББО-ны Менежентийн төлөвлөгөө зэрэг журам, зааврудад гарган ажилчдад танилцуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.


БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДЛЫН ХЯНАЛТЫН ЖУРАМ


ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГЫН ПРОЦЕССИЙН ЖУРАМ


4-3-1 БАТАРЕЙ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АЧИХ, БУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ ЗААВАР

*Зураг 6. Байгаль орчны хяналтын арга хэмжээний хүрээнд батлагдсан журам, зааврууд*

ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнг үнэлэх зорилгоор үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

**4.2 Агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ**

**Нөлөөллийн хамрах хүрээ.** Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр энэ төсөл хэрэгжиж буй талбай нь хүн ам, суурьшлийн бүс газарт хамааарах бөгөөд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа, химийн бодисын хадгалалт, ашиглалтаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээ, тохиолдох магадлалаар авч үзвэл 66.7 % бага, **маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд 66.6% нь ховор байна.** Гэхдээ үйлдвэрийн үйл ажиллагаанаас ялгарах боломжтой бохирдол, химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарснаас ажлын байрны орчны

агаарт нөлөөлж болзошгүй тул нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тохиолдолд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой.

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас дараах 2 төрлийн бохирдлыг агаарт бий болгох магадлалтай. Үүнд:

1. Ялгарах утаа
2. Дэгдэмтгий тоосонцор зэрэг болно.

Хаягдал хар тугалганы батарейг дахин боловсруулах үйлдвэрт яндангаас гарах утаа болон тоосонцрын гол бохирдуулагч нь хар тугалга байдаг. Хаягдал хар тугалганы батарейг дахин боловсруулах үйлдвэрээс гарах бохирдолтой холбоотой хэд хэдэн стандартууд манай улсад мөрдөгдөж байна. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 6. Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6342-2016)*

| № | Бохирдуулах бодисын нэр | Хэмжилтийн дундаж хугацаа | Хэмжих нэгж | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 1 тн/цагаас бага хүчин чадалтай зуух | 1 тн/цагаас дээш хүчин чадалтай зуух |
| 1 | Нийт тоос | 30 минут | мг/м$^3$ | 80 | 50 |
| | | 24 цаг | | 20 | 20 |
| 2 | Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | 30 минут | мг/м$^3$ | 200 | 150 |
| | | 24 цаг | | 100 | 50 |
| 3 | Хүхрийн давхар исэл ($SO_2$) | 30 минут | мг/м$^3$ | 200 | 300 |
| | | 24 цаг | | 100 | 100 |
| 4 | Азотын ислүүд (NOx) | 30 минут | мг/м$^3$ | 300 | 400 |
| | | 24 цаг | | 200 | 200 |
| 5 | Удаан задардаг органик бохирдуулагч бодисууд (Диоксин ПХДД, фуран ПХДФ | 6-8 цаг | мг/м$^3$ | 0.1 | 0.1 |
| 6 | Хлорт устөрөгч (HCl) | 30 минут | мг/м$^3$ | 60 | 60 |
| | | 24 цаг | | 10 | 10 |
| 7 | Фторт устөрөгч (HF) | 30 минут | мг/м$^3$ | 4 | 4 |
| | | 24 цаг | | 1 | 1 |
| 8 | Нийт нүүрсустөрөгч | 30 минут | мг/м$^3$ | 20 | 20 |
| | | 24 цаг | | 10 | 10 |
| 9 | Хар тугалга (Pb), түүний нэгдлүүд | 30 минут | мг/м$^3$ | 1 | 1 |
| | | 8 цаг | | 0.5 | 0.5 |
| 10 | Кадьми (Cd), түүний нэгдлүүд | 30 минут | мг/м$^3$ | 0.1 | 0.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 8 цаг | | 0.05 | 0.05 |
| 11 | Мөнгөн ус (Hg), түүний нэгдлүүд | 30 минут | мг/м$^3$ | 0.1 | 0.1 |
| | | 8 цаг | | 0.05 | 0.05 |

2025 оны 05 дугаар сарын 20, 09 дүгээр сарын 30-ны өдөр Үйлдвэрийн дотор болон гадна талбайн хэсгээс Цаг уур, орчны шинжилгээний газраас агаарын чанарын шинжилгээг хийлгэсэн. Тус шинжилгээ нь MNS 4585:2016-ын шаардлага, MNS 4990:2015 стандартын шаардлагыг хангасан.

### 4.3 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал, үнэлгээ

**Нөлөөллийн хамрах хүрээ**. 2024 онд Химийн бодисын агуулахын барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **харуулын байр барих** ажлыг төлөвлөж, уг барилгын ажил гүйцэтгэгдэх үед үүсч болзошгүй байгаль орчны сөрөг нөлөөллийг тодорхойлон, нөлөөллийг арилгах болон бууруулах арга хэмжээг тусгасан байсан.

Гэвч тайлант хугацаанд харуулын байрыг шинээр барилгын ажил явуулахгүйгээр, **байгаа барилга байгууламжийг ашиглах байдлаар** шийдвэрлэсэн тул уг барилгын ажил хийгдээгүй болно. Иймд 2025 онд харуулын байрны барилгын ажил хийгдээгүйтэй холбогдуулан **газрын гадарга, хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл гараагүй** болно. Энэхүү шийдвэр нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан “барилгын үеийн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах” зорилттой нийцэж, нөлөөлөл гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээ болсон.





Зураг 7. Харуулын байрыг шийдсэн байдал

### 4.4 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ

**Нөлөөллийн хамрах хүрээ.** Төсөл хэрэгжсэн талбай нь дунд зэргийн талхагдалд орсон бэлчээртэй, ургамлан нөмрөгийн арвин бүрхэц дунд зэрэг байна. Ургамалжилт нь ерөнхийдөө хүн, малын хөлд бага зэрэг талхлагдсан. Тэр нь ургамлын хэв шинжүүд хэвийн

байдлаар бус, тачир намхан (үндсэн хэсэг нь 3-6 см-ээс өндөргүй), хувирмал шинжээр илэрнэ. Харин огт ургамалгүй буюу маш сийрэг ургамалтай талбай (паркийн дэвсгэр, замаас гадна) байхгүй. Парк байрлаж байгаа толгод хоорондын хотос дэвсэгт ширэг улалж зонхилсон нугажсан хээрийн ургамалжилттай боловч хүн болоод техникийн нөлөөгөөр ургамал нөмрөгт нь бага зэрэг өөрчлөлт орж, сийрэг тачир болсон байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр үйлдвэрийн үйл ажиллагаа, химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх **нөлөөлөл 100% маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор тохиолдох магадлалд** орж байна. Энэ талаар гарч болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа, нөлөөллийн хэр хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл*

| № | Ажлын үе шат | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл |
|---|---|---|
| 1 | Харуулын байр барих барилгын үе шат | Барилга барих явцад барилгын шугам сүлжээний нүх ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг талхагдалд орох, улмаар хөрс үржил шимгүй болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас хөрс бүтцээ алдан салхиар зөөгдөх зэрэг нөлөөлөх үзүүлэх |

Төслийн хүрээнд үйлдвэрийн бүсэд хөдөлгөөний аюулгүй байдал болон орчны хамгаалалтыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Харуулын байрыг шийдэн үйлдвэрийн бүсэд зорчих хурдны хязгаарын тэмдгийг байршуулсан. Мөн үйлдвэрийн талбайн эзэмшил, газрын хил зааг дотор явган зам, автомашины зам, талбай зэргийг байгалийн чулуу, хайрга ашиглан хучилт хийн олон салаа зам гарахаас сэргийлэн нэг маршрутаар зорчих зохион байгуулалт бий болгосон. Хучилт хийгдээгүй сул хэсгийг **зүлэг ургах нөхцөлөөр хангаж**, зорчихгүй байхыг ажилчид, тээврийн хэрэгслийн жолоочдод зөвлөн ажиллаж байна. Энэ хөдөлгөөний зохицуулалт нь **зөвхөн хучилт хийсэн замаар зорчих**, орчны эвдрэлээс сэргийлэх, хөрс, ургамлын бүрхэвчийг хамгаалах зорилготой.





Зураг 8.Үйлдвэрийн бүсэд хайрган хучилттай зам талбай тохижуулсан байдал

## 4.5 Усан орчинд нөлөөлөх байдал, үнэлгээ

**Нөлөөллийн хамрах хүрээ.** Үйлдвэр нь үйлдвэрийн техникийн болон технологийн хэрэгцээнд “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн эзэмшлийн 2 гүний худгаас ашиглаж байна. Ахуйн хэрэглээний усыг Чандмань Налайх ОНӨААТҮГ-тай гэрээгээр хамтран ажиллаж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр үйлдвэрийн үйл ажиллагаа, химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100% бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 100% нь ховор тохиолдохоор байна.

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн химийн бодис, тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд алдагдан, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчиж, гадаргын болон газрын доорх усны усны чанарт дам байдлаар нөлөөлөх болзошгүй.

*Хүснэгт 8. Усан орчинд үзүүлж болзошүй сөрөг нөлөөлөл*

| № | Ажлын үе шат | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл |
|---|---|---|
| 1 | Барилгын ажлын үе шатанд | Усны тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам стандартыг мөрдөн ажиллаагүйгээс сөрөг үр дагавар, эрсдэл үүсэх |
| 2 | | Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд алдагдан, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчиж, гадаргын болон газрын доорх усны усны чанарт дам байдлаар нөлөөлөх болзошгүй |

## 4.6 Хог хаягдлын менежмент

**Нөлөөллийн хамрах хүрээ.**Барилгын ажлын явцад ахуйн болон барилгын хог хаягдал сард дунджаар 3.5 тн, жилд дунджаар 28.0 тн гарах бөгөөд хог хаягдлыг тусгайлан зассан хог хаягдал түр хадгалах цэгт цуглуулан Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулсан ба 2024 онд гэрээний дагуу 7-14 хоногийн давтамжтай хог хаягдлыг ачуулж байх болно. Энэ талаар гарч болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа, нөлөөллийн хэр хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 9. Хог хаягдлын менежмент, болзошгүй сөрөг нөлөөлөл*

| № | Ажлын үе шат | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл |
|---|---|---|
| 1 | Барилгын ажлын үе шатанд | Хог хаягдлын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам стандартыг мөрдөн ажиллаагүйгээс сөрөг үр дагавар, эрсдэл үүсэх |
| 2 | | Барилгын болон ахуйн хог хаягдлыг замбараагүй зайлуулах болон ажилчдын кэмпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдлоос үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй |
| 3 | | Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч гоожин хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй |

# 5. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Зорилго:** Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино.

### 5.1 Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөлтийн биелэлт

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Хог хаягдлын гэрээг холбогдох хот тохижилтын газартай гэрээ байгуулах | 4.400 мян.төг | Налайх “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай Хог хаягдлын төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу гүйцэтгэлийг хანган ажиллаж байна. | 100 % |
| 2 | Зөөврийн цэвэр усаар хангах гэрээг Чандмань налайх ОНӨААТҮГ-тай гэрээг байгуулах | 2.846 мян.төг | Зөөврийн цэвэр усаар хангах гэрээг “Чандмань налайх” ОНӨААТҮГ-тай 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн № 2025-05 дугаар гэрээтэй. | 100 % |
| 3 | Мэргэжлийн байгууллагатай хамтран аюултай хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах. | 500.0 Мян.төг | “Элемент” ХХК-тай химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх 2025 оны 04-р сарын 16-ны өдрийн № ХБ-25/073 дугаартай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан, гүйцэтгэлийг хანган ажиллаж байна. | 100 % |
| 4 | Ус, газар, хог хаягдал, агаарын бохирдлын хураамжийг гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд барагдуулах. | - | Төлөвлөгөөт хугацаанд хураамжуудыг төлсөн. | 100 % |
| 5 | Байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх. | 8,000.0 мян.төг | Байгаль орчны аудитыг “Алтан шанага” ХХК-аар 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ASH-25/01 дугаартай хамтран ажиллах гэрээний дагуу хийж гүйцэтгүүлсэн. | 100 % |
| 6 | Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй боловсруулан ажиллах. | - | “Электрокем Монгол” ХХК-ийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Налайх дүүргийн | 100 % |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Онцгой байдлын хэлтсээр батлуулахаар хүргүүлсэн. | |
| 7 | Галын аюулаас урьдчилан сэргийлэх, дохиолол хамгаалалтын төхөөрөмж суурилуулах, галын хор шалгах, заавар зөвлөмжийг байрлуулах | 3.200 мян.төг | Галын аюулаас урьдчилан сэргийлэх, дохиолол хамгаалалтын төхөөрөмж, самбар суурилуулан галын хорыг сар бүр шалган бүртгэн ажиллаж байна. Гал унтраах тактикийн дадлага сургалтыг зохион байгуулан галын төлөвлөгөөг батлуулсан. | 100 % |
| 8 | Эдэлбэр газрын үер, газар хөдлөлт, аянга, галын аюулгүй байдлыг хангасан хамгаалалттай, болзошгүй ослын үед ашиглах заавар, схем зургийг нүдэнд харагдахуйц газар ил байрлуулах | | | |
| 9 | Анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангагдах. | 800.0 мян.төг | Үйлдвэрийн байранд анхны тусламж үзүүлэх өрөөг тохижуулан, яаралтай тусламж үзүүлэх нөхцлаар бүрэн хангасан. Мөн нийт ажилтнуудыг “Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх” сургалтанд хамруулсан. | 100 % |
| 10 | Байгаль орчныг хамгаалах болон орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар ажиллагсад, үйлчилгээний ажилтнуудад тодорхой хугацаагаар байгаль орчны сургалт семинар зохион байгуулах | - | 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр нийт ажилчдад ХЭМАББО-ны зөвлөх Ч.Ганцолмон “ХЭМАББО-ны мэдлэг ойлголт өгөх” зорилгоор нийт 25 ажилтанд сургалт зохион байгуулсан. | 100 % |
| 11 | Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт улиралд нэг удаа хамрагдах. | 4308.0 мян.төг | “Бодь-Энх” ХХК-ийн “Топаз” эмнэлэгт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.Мөн “Налайхын эрүүл мэндийн төв”-тэй хамтран эрүүл мэндийн үзлэгийг хийлгэсэн. | 100 % |
| 12 | Ашиглагдаж буй техник, технологи, машин механизмын техник хэрэгслээс дуу шуугиан гарах бөгөөд орчинд үзүүлэх нөлөөлөл нь хязгаарлагдмал боловч тухайн орчинд | | Төслийн үйлдвэрлэл, ашиглагдаж буй техник, технологи, машин механизмын ажиллагаанаас дуу шуугиан үүсэх нь ажиглагдсан. Үүний орчны нөлөөлөл нь нийт орчинд хязгаарлагдмал боловч | 100 % |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажиллагсдад сөрөг нөлөөтэй тул хамгаалах хэрэгслээр хангах. | | ажиллагсадын эрүүл мэнд, ажлын бүтээмжид сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үнэлэгдсэн. Ажиллагсадыг сонсгол хамгаалах хэрэгсэл (чихний хамгаалалт, чихэвч гэх мэт)–ээр хангасан. Техник, тоног төхөөрөмжийн ажиллагааг үзлэг, засвар үйлчилгээний хуваарийн дагуу тогтмол хянаж, дуу шуугианы түвшинг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн үйлдвэрийн дотор дуу шуугианы шинжилгээг хийлгэсэн. | |
| **Нийт** | | **23,484.0** | | |

2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр нийт ажилчдад ХЭМАББО-ны зөвлөх Ч.Ганцолмон “ХЭМАББО-ны мэдлэг ойлголт өгөх” зорилгоор нийт 25 ажилтанд сургалт зохион байгуулсан.





Сургалтын сэдэв:
Огноо: | Цаг: | Байршил:
Сургалт өгсөн шалтгаан:

Электрокем Монгол" ХХК-ийн ажилчдын ХЭМАБ-ын сургалтанд хамрагдсан ажилтны бүртгэл:

| № | Ажилтны овог нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Х.Ганболд | ТУЗ-ын дарга | |
| 2 | М.Авирмэд | Үйлдвэрийн дарга | |
| 3 | Л.Дуламсүрэн | Үйл ажиллагааны менежер | |
| 4 | Г.Болормаа | Нягтлан бодогч | |
| 5 | М.Нацагсүрэн | Хүний нөөцийн менежер | |
| 6 | Э.Оюунтуяа | ХЭМАББО-ны инженер | |
| 7 | Д.Батбаатар | ХЭМАБ-ын ажилтан | |
| 8 | Б.Даваадорж | Ээлжийн ахлах | |
| 9 | Н.Нэргүй | Ээлжийн ахлах | |
| 10 | Т.Эсэмбол | Ээлжийн ахлах | |
| 11 | М.Цэцэгхэр | Оператор | |
| 12 | Д.Нүрзэд | Тогооч | |
| 13 | Т.Кенжегүл | Үйлчлэгч | |
| 14 | А.Амгаланбаяр | Үйлдвэрийн нярав | |
| 15 | Amit Poonia | Ээлжийн мастер | |
| 16 | Arvind Singh | Ачигчийн оператор | |
| 17 | Karan Singh | Ачигчийн оператор | |
| 18 | Himmat Singh | Туслах ажилтан | |
| 19 | Sandeep Singh | Туслах ажилтан | |
| 20 | Ladu Ram | Туслах ажилтан | |
| 21 | Hareesh | Туслах ажилтан | |
| 22 | Ajit | Туслах ажилтан | |
| 23 | Nareendr | Тогооч | |




Зураг 9. Сургалт зохион байгуулсан талаар

**5.1.5 Байгаль орчны аудит хийлгэх ажлын хүрээнд:**

2021-2025 оны Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээнд төслийн хэрэгжилтийн хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэнэ гэж тусгасан. Төслийн хувьд 2024 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул үйл ажиллагааны 2 дах жилдээ байгаль орчны аудитыг хийлгэж байна.

Энэхүү заалтын дагуу “Электрокем Монгол” ХХК нь аудитын үнэлгээ хийлгэх үүргээ биелүүлж 2025 оны 09 дүгээр сарын 23 -ны өдрийн ASH-25/01 дугаартай “Байгаль орчны аудит хийлгэх” ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Алтан шанага” ХХК-аар байгаль орчны аудитыг хийлгэж байна.



*Зураг 10. Байгаль орчны аидитын гэрээ*

**5.1.6 Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй боловсруулан ажиллах ажлын хүрээнд:**

2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 8-БТГ-031 дугаар гэрээний дагуу “Уст бэлчир” ХХК-аар Гамшгийн эрсдлийн үнэлгээг хийлгүүлсэн. Үнэлгээний хүрээнд дараах чиглэлүүдийг хамруулсан:

- Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүсч болзошгүй байгалийн гамшиг, гал түймэр, осол, хүн амын эрүүл мэнд болон хөрөнгө оруулалтанд үзүүлэх эрсдэлийг тодорхойлсон;
- Эрсдэлийн түвшин, гарах нөхцөл, болзошгүй сөрөг нөлөөллийн боломжит үр дагаврыг үнэлсэн;
- Эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хариу арга хэмжээ авах талаар зөвлөсөн.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний дагуу болзошгүй байгалийн гамшиг, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор байгууллагын **гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан гаргасан** бөгөөд уг төлөвлөгөөг **Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсээр батлуулахаар** хүргүүлсэн. Мөн байгалын гамшиг, гал түймрийн үед хариу арга хэмжээ авах чадварыг дээшлүүлэх зорилгоор **Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс** болон **Гал түймэр унтраах, аврах 28-р анги**-тай хамтран ажилласан. Хамтын ажиллагааны хүрээнд:

- Компанийн нийт ажилчдыг **гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зөв ашиглах** талаар сургаж, дадлагажуулсан;

- Гал түймрийн үед **галыг илрүүлэх, галын тархалтыг зогсоох, хохирлыг багасгах** чиглэлээр **тактикийн сургалт, дадлага** зохион байгуулсан;
- Дадлага сургалт нь **Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс болон үйлдвэрийн байранд** амжилттай зохион байгуулагдсан;



Зураг 11. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал унтраах тактикийн сургалт




Зураг 12. Галын аюулгүй байдлын дүгнэлт, сургалтын төлөвлөгөө

Төслийн хүрээнд гал түймэр болон түүнээс үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чадавхийг үнэлэх зорилгоор **галын аюулгүй байдлын дүгнэлт** гаргуулсан. Үйлдвэрийн байранд нийтдээ галын гидрант 5 ш, галын хор 6кг – 30 ш, өлгөдөг 10кг – 30ш, түрдэг 20кг- 10ш, тунгус – 25 ш, утаа мэдрэгч – 30 ш, ослын гэрэлтүүлэг – 4 ш, гарцын тэмдэг тэмдэглэгээ – 8 ш, дуут дохиолол – 5 ш, галын булан – 2 ком, утаа зайлуулах систем, галын аюулаас урьдчилан сэргийлэх самбар – 2 ширхэгийг тус тус байршуулсан байна. Галын аюулгүй байдлын үзлэгийг сар бүр хийн тэмдэглэсэн байна. Үзлэгээр шаардлага хангахгүй болсон галын хор 6 кг – 11 ш, түрдэг 20кг – 3ш илэрсэнг дахин цэнэглүүлэн хэвийн ажиллагааг хангасан.



*Зураг 13. Галын хэрэгсэл байршуулсан байдал*

**5.1.6 Анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангагдах ажлын хүрээнд:**

Төслийн үйл ажиллагаанд оролцож буй нийт ажилчдыг **анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангах** шаардлагыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан. Иймд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Үйлдвэрийн бүсэд анхны тусламж үзүүлэх өрөөг тохижуулсан. Анхны тусламжийн өрөөнд шаардлагатай анхны тусламжийн хэрэгсэл, самбарнуудыг байршуулсэн.
- Компанийн нийт ажилчдад анхны тусламж үзүүлэх, яаралтай тусламжийн үед хариу арга хэмжээ авах мэдлэгийг сайжруулах зорилгоор Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран мэргэжлийн албан хаагчдын удирдлага дор сургалт, дадлага зохион байгуулсан.
- Сургалтаар ажилчид осол, гэмтэл, гал түймэр болон бусад эрсдлийн үед хурдан шуурхай, аюулгүй хариу арга хэмжээ авах мэдлэг, ур чадвар эзэмшсэн.
- Анхны тусламжийн багаж хэрэгсэл болон эмнэлгийн хангамжийг тогтмол шалгаж ажиллаж байна.

Эдгээр арга хэмжээ нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, төслийн үеийн эрсдлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.






*Зураг 14. Анхны тусламжийн өрөөг тохижуулсан байдал*

2025 оны 08 дугаар сарын 19-ны өдөр Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран компанийн нийт ажилтнуудад зохион байгуулж “Түлэгдэлтийн үед авах хариу арга хэмжээ” сэдвээр мэс заслын эмч “Анхан шатны тусламж үзүүлэх” сэдвээр яаралтай тусламжийн эмч нар танхимын сургалт орсон.






ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

**Цахим гүйлгээний баримт**

Хүсэлтийн лавлах дугаар: **S25804164202508193** Татсан огноо: **2025-10-29 14:04**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8125102557**<br>MN540015008125102557 | **MN680090100200420001** | **700,000.00 MNT** | **Амжилттай** |
| Шилжүүлэгчийн нэр<br>**ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ** | Хүлээн авагчийн нэр<br>**НД.ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДЭЛ** | Гүйлгээний утга<br>**ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК-С АНХАН ШАТНЫ СУРГ** | |
| | Хүлээн авагчийн банк<br>**Төрийн сан** | Гүйлгээний огноо<br>**2025-08-19** | |





*Зураг 15. Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалт*

Үйлдвэрийн бүсэд **аюулгүй ажиллагааны тэмдэг**, ажилчдын аюулгүй байдлыг хангах **нүд угаах цэг** зэрэг шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулсан.








*Зураг 16. Тэмдэг тэмдэглэгээ, нүд угаах цэг байршуулсан байдал*

### 5.1.11 Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу нийт ажилтнуудыг эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, ажлын эрсдэлээс хамгаалах зорилгоор эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулж байна. Үүнтэй холбогдуулан:

- **“Бодь-Энх” ХХК-ийн “Топаз” эмнэлэгт** ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан;
- **“Налайхын эрүүл мэндийн төв”-тэй** хамтран ажлын байрны эрсдэлийн нөлөөг үнэлэх үзлэгийг хийлгэсэн;
- Мөн “**Нийгмийн эрүүл мэндийн төв”**-өөр ажилчдын цусан дах хар тугалганы агууламжийг шинжилсэн. Үзлэг, шинжилгээний үр дүнд ажилчдын эрүүл мэндийн байдал тогтмол хянагдаж, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах чадавхыг нэмэгдүүлсэн.



ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: S95643299202504153 Татсан огноо: 2025-10-29 13:56

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 8125102557<br>MN540015008125102557 | 456103917 | 1,045,000.00 MNT | Амжилттай |

Шилжүүлэгчийн нэр: ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ
Хүлээн авагчийн нэр: БОДЬ-ЭНХ ХХК
Хүлээн авагчийн банк: ХУД ХӨГЖ ТӨВ БАНК
Гүйлгээний утга: ЕЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК-С ШИНЖИЛГЭЭНИ Й ТӨ
Гүйлгээний огноо: 2025-04-15





ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: GB115047202503171 Татсан огноо: 2025-10-29 13:55

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 8125102557<br>MN540015008125102557 | 3615135610<br>MN950015003615135610 | 380,000.00 MNT | Амжилттай |

Шилжүүлэгчийн нэр: ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ
Хүлээн авагчийн нэр: РАДИАНТСКАН ХОЛДИНГ ХХК
Хүлээн авагчийн банк: Голомт банк
Гүйлгээний утга: ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК-С MRI ТӨЛБӨР 6352901
Гүйлгээний огноо: 2025-03-17



*Зураг 17. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр төлсөн баримт*

# 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

## 6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

*Хүснэгт 10. Агаарын чанарын бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Хайлуулах үйл ажиллагааны явцад ялгаран гарах утааг хянах иж бүрэн систем суурилуулах, хар тугалганы батарейг дахин боловсруулах үйлдвэрийн хайлуулах үйл ажиллагааны явцад ялгарах утааг хянах системийн найдвартай үйл ажиллагааг хангах үүднээс үйлдвэр нь олон улсын | - | Хар тугалганы батарей дахин боловсруулах үйлдвэрийн хайлуулах үйл ажиллагааны явцад утаа ялгарах эрсдэлийг бууруулах, хяналт тавих иж бүрэн систем суурилуулах төлөвлөгөөг Байгаль орчны | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | практикт өргөн хэрэглэгддэг найдвартай ажиллагааг хангах хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах | | менежментийн төлөвлөгөөнд тусгасан. Гэвч тайлант хугацаанд уг арга хэмжээ биелэгдээгүй бөгөөд системийг суурилуулах, хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр судалж, ажлыг дараа онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. | |
| 2 | Ялгаран гарах утаа тоосонцрын бохирдлыг хянах 2 төрлийн иж бүрэн систем суурилуулах /хайлуулах үйл ажиллагааны явцад гарах тоосонцрын барих, цэвэршүүлэх үйл ажиллагааны явцад гарах тоосонцрын хянах/, улмаар бохирдлыг хянах систем нь Монгол улсын стандарт, ажлын байрны нөхцөл, шаардлагыг хангасан байх. Хайлуулах болон цэвэршүүлэх үйл ажиллагаанаас гарах дэгдэмтгий тоосонцрыг хянах систем нь эргэлдэх зуухыг цэнэглэх ам, зуухны яндан болон хайлсан тугалга гоожих ам зэргээс гарах аливаа утаа, тоосонцрыг барих зориулалтай байх | - | | - |
| 3 | Үйлдвэрийн хайлуулах болон цэвэршүүлэх үйл ажиллагаанаас хар тугалганы тоосонцор, хүхрийн хүчлийн уур үүсэхээс сэргийлж агаарын чанарын хяналтыг агаарын чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх. | 397.0 мян.төг | Агаарын чанарын шинжилгээг 2025 оны 05 дугаар сарын 20 болон 09 дүгээр сарын 12 -нд “Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори”-оор хийлгэсэн. | 100% |
| 4 | Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа ууршиx, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг | Үйл ажилла-гааны туршид | Үйл ажиллагааны явцад “Химийн бодисын удирдлага, зохицуулалтын журам” боловсруулан батлаж журмыг мөрдөн ажиллаж байна. Химийн бодисуудыг ХАЛМ-ын дагуу химийн бодисын агуулахад хадгалан, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмаар ашиглаж байна.<br>Мөн химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөж агуулах дахь үлдэгдэл, хугацаа | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эхэлж ашиглах зарчмыг баримтлах. | | зэргийг хянаж байна. Эдгээр арга хэмжээ нь химийн бодисын аюулгүй байдлыг хангах, орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилготой хэрэгжиж байна. | |
| 5 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын ууроар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар хангаж ажиллах | Үйл ажилла-гааны туршид | Үйлдвэр болон химийн бодисын агуулахад ажиллаж буй ажиллаггсад нь ажил гүйцэтгэхдээ ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бүрэн гүйцэт өмсөн ямар нэгэн осол, эрсдэлээс сэргийлэн аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна. | 100% |
| 6 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын хадгалах нөхцөлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх. Үйлдвэр, химийн бодисын агуулахад шатах, гал авалцах эх үүсвэр болон шатамхай, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бодис, бүтээгдэхүүнийг нэг дотор хадгалахгүй байх | Үйл ажилла-гааны туршид | Химийн бодисуудыг Хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу химийн бодисын агуулахад хадгалсан. | 100% |
| Нийт | | | | |

Үйлдвэрийн үйл ажиллагаанд Содын үнс болон Шохой ашигладаг бөгөөд эдгээр 2 бодисыг ХАЛМ-ын дагуу химийн агуулахад аюулгүй хадгалдаг.

- Хадгалах агуулахыг зохих шаардлагад нийцүүлэн барьсан;
- Хуучин бодисыг эхлээд ашиглах зарчмыг баримталдаг (FIFO – First In, First Out);
- Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэлийг тогтмол хөтөлж, үлдэгдэл, хадгалах хугацааг хянадаг;

Эдгээр арга хэмжээ нь химийн бодисоос үүдэх эрсдлийг бууруулах, орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилготой хэрэгжиж байна.



*Зураг 18. Хор аюулын лавлан мэдээлэл*

Шохойн мэдээ / Lime inventory (10 сар)

| Нэр / Name | Нэгж / Unit | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Авсан шохой / Lime in | кг/kg | | | | | | | | | | | | | | |
| Хэрэглэсэн шохой / Lime out | кг/kg | 675 | | | | | | 375 | 725 | | | 1,125 | 775 | 800 | |
| Зөрүү / Balance | кг/kg | -675 | 0 | 0 | 0 | 0 | 0 | -375 | -725 | 0 | 0 | -1,125 | -775 | -800 | 0 |
| Үлдэгдэл / Balance | кг/kg | 13,043 | 13,043 | 13,043 | 13,043 | 13,043 | 13,043 | 12,668 | 11,943 | 11,943 | 11,943 | 10,818 | 10,043 | 9,243 | 9,243 |

| Нэр / Name | Нэгж / Unit | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Авсан шохой / Lime in | кг/kg | | | | | | | | | | | 13,986 | | | |
| Хэрэглэсэн шохой / Lime out | кг/kg | | | | | | | | | | | | | | |
| Зөрүү / Balance | кг/kg | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 13,986 | 0 | 0 | 0 |
| Үлдэгдэл / Balance | кг/kg | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 9,243 | 23,229 | 23,229 | 23,229 | 23,229 |

10 сар

| Нэр / Name | Нэгж / Unit | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Авсан содны үнс / Soda ash inventory | кг/kg | | | | | | | | | | | | | | |
| Хэрэглэсэн содны үнс / Soda ash inventory | кг/kg | | | | | | | | | 300 | 650 | 650 | 700 | 650 | 780 |
| Зөрүү / Balance | кг/kg | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | -300 | -650 | -650 | -700 | -650 | -780 |
| Үлдэгдэл / Balance | кг/kg | 10,582 | 10,582 | 10,582 | 10,582 | 10,582 | 10,582 | 10,582 | 10,582 | 10,282 | 9,632 | 8,982 | 8,282 | 7,632 | 6,852 |

| Нэр / Name | Нэгж / Unit | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 10 сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Авсан содны үнс / Soda ash inventory | кг/kg | | | | | | | | | | 14,400 | | | | | 14,400 |
| Хэрэглэсэн содны үнс / Soda ash inventory | кг/kg | 550 | 450 | | | | | | | | | | | | | 4,730 |
| Зөрүү / Balance | кг/kg | -550 | -450 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 14,400 | 0 | 0 | 0 | 0 | 9,670 |
| Үлдэгдэл / Balance | кг/kg | 6,302 | 5,852 | 5,852 | 5,852 | 5,852 | 5,852 | 5,852 | 5,852 | 5,852 | 20,252 | 20,252 | 20,252 | 20,252 | 20,252 | 20,252 |




*Зураг 19. Химийн бодисын ашиглалтын бүртгэл*

### 6.2 Цаг уур, уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

*Хүснэгт 11. Цаг уур, уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэржилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах | - | Үйлдвэр болон химийн бодисын агуулахыг “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал. БНбД 21-01 -02”, -т заасан шаардлагыг хангасан материалаар барьж тохижуулсан. | 100% |
| 2 | Үйлдвэр, химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх. Хаягдал батарей, химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгалах | - | Химийн бодисыг химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээллийн дагуу хадгалдаг бол хаягдал батарейг үйлдвэр дотор батарей хураах хэсэгт зориулалтын саванд тус тус хадгалдаг. | 100% |
| 3 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механик бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавихаас гадна бодисыг долоо хоногт 1 удаа шалгаж хяналтыг тогтмол | - | Үйлдвэр болон химийн бодисын агуулахад долоо хоног, сар болгон үзлэг хийн, бүрэн бүтэн байдал, хяналт тавин тэмдэглэдэг. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх | | | |
| Нийт | | | | |

6.2.1 Үйлдвэр болон химийн бодисын агуулахыг “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал. БНбД 21-01 -02”, -т заасан шаардлагыг хангасан материалаар барьж тохижуулсан. Галын аюулгүй байдлыг дүгнэлтийг өмнөх хэсэгт оруулсан.

6.2.2, 6.2.3 Хор аюултай химийн бодисыг хооронд нь нийцэх байдлыг харгалзан тусад нь хадгалсан. Хаягдал батарей, химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс болон шууд нарны гэрэлд өртөхгүй нөхцөлд байрлуулсан. Ингэснээр химийн бодисын эвдрэл, урвал, шаталтын эрсдлийг бууруулж, агаарын бохирдол, хорт уур ялгаралтыг хязгаарласнаар уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулна. Сар бүр үйлдвэр болон химийн агуулахад тогтмол үзлэг хийн, бүрэн байдалд хяналт тавин ажилладаг.






*Зураг 20. Үйлдвэрт хаягдал аккумлятор, Химийн агуулахад химийн бодис хураасан байдал*







*Зураг 21. Үйлдвэр болон Химийн агуулахад үзлэг хийсэн тэмдэглэл*

### 6.3 Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

*Хүснэгт 12. Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөөгний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэрийн түүхий эд хадгалах, ашиглах, хайлуулах болон цэвэршүүлэх үйл ажиллагаанаас хар тугалга, хүхрийн хүчил алдагдахаас урьдчилан сэргийлэх, хөрсөн бүрхэвчийн чанарын хяналтыг хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх | - | Үйлдвэрийн түүхий эд хадгалах, ашиглах, хайлуулах болон цэвэршүүлэх үйл ажиллагаанаас хар тугалга, хүхрийн хүчил алдагдахаас урьдчилан сэргийлж ажиллаж байна. Мөн хөрсний шинжилгээг “Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори”-оор хийлгэсэн. | 100% |
| 2 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх | - | Үйлдвэр болон агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт авч ажиллаж байна. | 100% |
| 3 | Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх | - | 4-3-1 Батарей цуглуулах, тээвэрлэх, ачих, буулгах үеийн үйл ажиллагааны стандарт зааврыг боловсруулан, зааврыг мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 4 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого | 1200.0 мян.төг | Үйлдвэр болон химийн бодисын агуулах, түлшний агуулах, хаягдал аккумлятор тээвэрлэх автомашинд асгаралын иж бүрдлүүдийг байршуулсан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх | | | |
| Нийт | | | | |

**6.3 Хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын хүрээнд:**

Үйлдвэр болон химийн бодисын агуулах, түлшний агуулах, хаягдал аккумлятор тээвэрлэх автомашинд асгаралын иж бүрдлүүдийг байршуулсан. Энэхүү иж бүрдэлд асгарал, алдагдал гарсан тохиолдолд хэрэглэх шингээгч материал, хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, хүрз, хогийн шүүр зэрэг шаардлагатай багаж хэрэгсэл багтсан. Мөн “4-Ж-28 Асгаралтын хариу арга хэмжээний журам” болон” Химийн ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө”-г боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.




Зураг 22. Асгаралтын иж бүрдлийг байршуулсан байдал


АСГАРАЛТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

Зураг 23. Асгаралтын хариу арга хэмжээний журам

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээг хийснээр химийн бодисын асгаралт, алдагдал, шаталт зэрэг ослын эрсдлийг бууруулах, хөрсний болон агаарын бохирдлыг

урьдчилан сэргийлэх, уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хянахад тустай.

Дээрх зурагт харуулсан асгаралтын хариу арга хэмжээний журамд тусгаснаар ямар нэгэн асгаралт үүссэн тохиолдол бүрт тухайн асгаралтыг бүртгэж, мэдээллийг **асгаралтын бүртгэлд тэмдэглэн** баримтжуулж байна. Энэхүү бүртгэл нь асгаралтын давтамж, шалтгааны дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах үндэс болж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг баталгаажуулж байна. Одоогийн байдлаар үйл ажиллагааны явцад үүссэн асгаралт бүртгэгдээгүй байна.

### 6.4 Усны чанар, найрлагад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

*Хүснэгт 13. Усны чанар, найрлагад нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Гүний худгийг тоолууржуулах, тоолуурын заалыг үндэслэн төлбөр төлж байх шаардлагатай. Нөгөө талаар тус байгууллагын хоногийн ус хэрэглээ 50 м3 -ээс бага хэмжээтэй тул Налайх дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт, гэрээ байгуулан ажиллах | 150.0 мян.төг | 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дугаар 422, 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Дугаар 2025/1814 Худаг гаргах зөвшөөрөлтэй. Гүний худгийг тоолууржуулсан. | 100% |
| 2 | Үйлдвэрийн түүхий эд хадгалах, ашиглах, хайлуулах болон цэвэршүүлэх үйл ажиллагаанаас хар тугалга, хүхрийн хүчил алдагдахаас урьдчилан сэргийлэх, усан орчны чанарын хяналтыг хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх | 200.0 мян.төг | Үйлдвэрийн түүхий эд хадгалах, ашиглах, хайлуулах болон цэвэршүүлэх үйл ажиллагаанаас хар тугалга, хүхрийн хүчил алдагдахаас урьдчилан сэргийлж, усан орчны чанарын хяналтыг хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан зөвлөмжийн дагуу усны чанарын шинжилгээг “Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори” болон “Хими, хими технологийн хүрээлэн”-ээр хийлгэсэн. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Ахуйн болон аюултай хог хаягдал, хар тугалгат хүчлийн батарейг хадгалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан агуулах, түр хадгалах талбай байгуулах | | Үйлдвэр дотор стандартын шаардлага хангасан задгай агуулахтай. | 100% |
| 4 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх | Үйл ажиллагааны туршид | Үйлдвэр болон агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт авч ажиллаж байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжлүүснээр химийн бодисын нэвчилт, алдагдлын эрсдлийг бууруулах, хөрсний болон усны бохирдлоос урьдчилан сэргийлэх, ажилтан, орчны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг болно. | 100% |
| 5 | Үйлдвэр, химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах ажиллах | | Үйлдвэр, химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хانган ажилладаг: | 100% |
| Нийт | | | | |

6.4.1 Гүний худгийг тоолууржуулах, тоолуурын заалыг үндэслэн төлбөр төлж байх шаардлагатай. Нөгөө талаар тус байгууллагын хоногийн ус хэрэглээ 50 м3 -ээс бага хэмжээтэй тул Налайх дүүргийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт, гэрээ байгуулан ажиллах

Үйлдвэрийн дотор болон гадна 2 гүний худагтай. Үйлдвэр доторх худгийг үйлдвэрийн ахуйн болон техникийн хэрэгцээний усыг хангах зориулалтаар ашиглагдаж байна. Харин гаднах худгийг  одоогоор ашиглагдаагүй байна.  2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дугаар 422, 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Дугаар 2025/1814 Худаг гаргах зөвшөөрөлтэй. Гүний худгийг тоолууржуулсан.




*Зураг 24. Гүний худгийн зөвшөөрөл, тоолуурын гэрчилгээ*



*Зураг 25.  Үйлдвэр дотор гүний худгийн харагдах байдал*

2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн №02 дугаартай “Налайхын барилгын материал үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ-тай хийсэн гүний худгаас үйлдвэрлэлийн зориулалтаар ус хэрэглэх гэрээний дагуу тоолуурын заалтаараа паркад усны төлбөрөө төлсөн.   Манай төсөл хэрэгжүүлж буй газар, гүний худаг, худаг гаргах зөвшөөрөл нь паркийн нэр дээр байдаг тул паркаас өгсөн мэдэгдлийн дагуу парктай гэрээ байгуулан усны төлбөрөө төлж байсан боловч “Нийслэлийн байгаль орчны газар”-аас паркыг эрх бүхий байгууллага учраас ус ашиглуулах гэрээ байгуулах эрхгүй талаар мэдэгдсэн болно. Иймд бидний байгуулсан гэрээ нь хууль, журамд нийцэхгүйд тооцогдож байгаа тул холбогдох журмын дагуу ус ашиглалтын гэрээг шинэчлэн байгуулах шаардлага үүссэн. Иймээс бид байгаль орчныг хамгаалах, ус ашиглалтын асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах зорилгоор “Нийслэлийн Байгаль орчны газар”-тай холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, ус ашиглалтын зөвшөөрлийг авах чиглэлээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд:

- Зөрчилд ноогдуулсан торгуулийг төлсөн.

- Худаг гаргах зөвшөөрлийг “Нийслэлийн байгалт орчны газар” – аас авсан.
- Худгийн пасспортыг “Нийслэлийн байгалт орчны газар”-аар баталгаажуулсан.
- Усны газарт боломжилт нөөцийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг өгсөн байна.
- Боломжит нөөцийн дүгнэлт гарангуут бусад шаардагдах дүгнэлт, зөвшөөрлийн авч ус ашиглах гэрээг байгуулна.




*Зураг 26. Үйлдвэрийн доторх худганд худаг гаргах зөвшөөрөл авч, худгийн пасспортыг баталгаажуулсан байдал*




*Зураг 27. Усны газарт ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах хүсэлт болон усны торгууль төлсөн баримт*

### 6.5 Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

*Хүснэгт 14. Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Төслийн үйл ажиллагаа, осол аваарын үед техникийн | - | Төслийн үйл ажиллагаа, осол аваарын үед техникийн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байнга авч байх шаардлагатай | | гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байнга авч ажиллаж байна. Ямар нэгэн бодис асгарсан, хөрсөнд нэвчсэн тохиолдол байхгүй. | |
| Нийт | | | | |

## 6.6 Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

*Хүснэгт 15. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэр, химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн дутагдлаас үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих | Үйл ажиллагааны явцад | Үйлдвэрийн байр болон агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлж, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавин ажилладаг. | 100% |
| 2 | Үйлдвэр, химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх, мэргэжлийн сургалтад хамрагдах | 3 удаа | Үйлдвэрийн ХЭМАББО-ны инженер нь Империал Партнерс ХХК-иас санаачлан БОУАӨЯ болон ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан “Химийн хорт бодистой харьцах ажилтны ур чадварыг хөгжүүлэх” сэдэвтэй онол, арга зүйн танхимийн сургалтанд хамрагдсан. Мөн Хими, химийн технологийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Аюултай хог хаягдлын зохистой менежмент”, БОУАӨЯ-тай | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд шинжилгээний болон хүний нөөцийн чадавхийг сайжруулах” төслийн хүрээнд “Аюултай хог хаягдлын шинжилгээний арга зүй” сэдэвтэй онол арга зүйн сургалтанд тус хамрагдсан. | |
| 3 | Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна. | Үйл ажиллагааны туршид | Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагааны явцад ашиглах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажил гүйцэтгэх дараалал, ажил гүйцэтгэхэд шаардалагатай багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэгслүүдийг нэг бүрчлэн нарийн тусгасан үйл ажиллагааны стандарт зааврыг боловсруулан гаргаж гүйцэтгэх захирлаар батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100% |
| 4 | Ажлын байран доторх бага хэмжээтэй химийн бодис хадгалах зөөврийн агуулахыг шат, аврах гарц, хонгилын эргэлтийн өнцөг, давчуу хонгил гэх мэт хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулах эрсдэлтэй газар болон албан тасалгаа, амрах өрөө, цайны газар, | - | Үйлдвэрт химийн бодисыг ашиглахдаа задгай агуулахад байршуулан ашигладаг. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | биеийн тамирын өрөө, эмнэлгийн тусламжийн өрөөний ойр байрлуулах, орон сууц, худалдаа үйлчилгээний газрын болон албан байгууллагын байшингийн зоорийн давхарт хадгалахгүй байх | | | |
| Нийт | | | | |

Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагааны явцад ашиглах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, ажил гүйцэтгэх дараалал, ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэгслүүдийг нэг бүрчлэн нарийн тусгасан үйл ажиллагааны стандарт зааврыг боловсруулан гаргаж гүйцэтгэх захирлаар батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

- 4-3-1 Батарей цуглуулах, тээвэрлэх, ачих, буулгах үеийн үйл ажиллагааны стандарт заавар
- 4-3-2 Бутлан ангилах цехийн үйл ажиллагааны стандарт заавар
- 4-3-3 Хүчил саармагжуулах цехийн үйл ажиллагааны стандарт заавар
- 4-3-4 Хайлуулах цехийн орц бэлтгэх үйл ажиллагааны стандарт заавар
- 4-3-5 Хайлуулах цехийн үйл ажиллагааны стандарт заавар

## 7.Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт

Ногоон байгууламжийн төлөвлөгөөний гол зорилго нь төсөл хэрэгжих газрын байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор ногоон байгууламжийг барьж байгуулах явдал юм.

Энэ төлөвлөгөөг бодитойгоор хэрэгжих үндэс болсон цаг агаарын нөхцөл, хөрсний хэв шинжид зохицсон мод, сөөг, олон наст ургамал сонгосон ба эдгээр нь дасан зохицол сайтай, манай орны аль ч бүс бүслүүрт ургах чадвартай юм. Түүнчлэн ногоон байгууламжийн төлөвлөгөөнд сонгосон ургамлын зүйлүүд нь нийслэл хотын ногоон байгууламжид өргөнөөр ашиглагддаг бөгөөд үр дүн сайтай байдаг.

Ногоон байгууламжийн тариалалтыг хийхэд тохиромжтой мод сөөгийг сонгохдоо батлагдсан Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэсэгт тусгасан 2-р хувилбарыг сонгосон. Тус ногоон байгууламжийг амжилттай тариалснаар байгаль орчиндээргээр нөлөөлөхийн зэрэгцээ төсөл хэрэгжиж буй талбайн тодорхой хэмжээний хөрсийг хамгаалж элэгдэл эвдрэлд өртүүлэхгүй байх, төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад ач холбогдолтой.

**Эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр өгөөж:**

**Байгаль орчинд:**

- Ногоон орчныг бий болгоно.

- Хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаална.
- Тоосжилт үүсэхээс сэргийлнэ. ✓ Ургамлан нөмрөгийг тогтворжуулна.
- Агаар цэвэршүүлнэ.
- Ногоон байгууламжийн нэг давуу тал нь өвлийн цагт цасыг сайн хуримтлуулдаг.

Эдийн засагт:

- Үйлдвэрийн хашаан доторх өнгө үзэмжийг сайжруулна.
- Ногоон байгууламжийг бий болгосноор экологи-эдийн засгийн хохирлоос урьдчилан сэргийлнэ.

Нийгэмд:

- Агаарын бохирдлыг багасгахад тодорхой хэмжээгээр нөлөөлнө.
- Гоозүйн болон хүний эрүүл мэндэд тустай
- Тухайн компанийн олон талт үйл ажиллагааны нэгээхэн хэсэг болсон “Ногоон" бодлогыг илтгэнэ.
- Нийт улс орны байгаль орчны бодлогыг дэмжинэ.

Нарс нь үйлдвэрийн бүсийн агаарын чанарыг сайжруулахад чухал нөлөөтэй. Тоосжилтийг 20-30% хувь бууруулах боломжтой. Нүүрсхүчлийн хийг шингээж, хүчилтөрөгч ялгаруулснаар агаарын найрлага тэнцвэржиж, ажилчдын эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн х**өрсний тогтвортой байдлыг нэмэгдүүлж**, элэгдэл, салхи, тоосжилтоос хамгаална.

2025 онд нийт 40 ширхэгд мод тарьсан. Үлдсэн мод болон зүлэгжүүлэлтийн ажлыг 2026 оны менежментийн төлөвлөгөөнд тусган гадна тохижилтын ажил хийгдэхэд 05 болон 10 дугаар сард хийж гүйцэтгэнэ.



*Зураг 28. Мод тарьж буй байдал*

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:32307955

Системийн огноо/System Date:2025.10.22 16:51:33

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт/From | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5032459325 | Нэр/Name<br>Л*********Н ДУЛАМСҮРЭН | Дүн/Amount<br>4,000,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| / Дөрвөн сая төгрөг / | | | | |
| Кт/To | Банкны дугаар/Branch No<br>05<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>5753686030 | Банкны нэр/Bank Name<br>Khan Bank - Хаан банк<br>Нэр/Name<br>А******Й БЯМБААХҮҮ | 4,000,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
Электрокем Монгол ХХК

*Зураг 29. Мод авсан баримт*

## 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

### 8.1 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Үйл ажиллагааны явцад үйлдвэрийн талбай болон ойр орчмын бүсээс түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй болно. Хэрэв археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана

### 8.2 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт

Төслийн хэрэгжилтийн хүрээнд үйлдвэрлэлийн болон сөрөг нөлөөллийн бүсийг тодорхойлж, тухайн бүсэд оршин сууж буй хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын байршлын судалгааг хийсэн. Судалгааны үр дүнгээр уг бүсэд иргэд, айл өрх, оршин суугчид, байгууллага, аж ахуйн нэгж байхгүй, мөн төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөл хүлээж, зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай хүн ам байхгүй болно.

## 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн болон барилгын хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, ариутгах, тээвэрлэх графикийг гаргаж, Дүүргийн Засаг даргын тамгын газартай ахуйн болон барилгын хог хаягдлын гэрээний дагуу тогтоосон хугацаанд нь ачуулж байх | 4.400 мян.төг | Налайх “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай Хог хаягдлын төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу гүйцэтгэлийг ханган ажиллаж байна. | 100 % |
| 2 | Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлнэ | - | Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлж байна. | 100 % |
| 3 | Барилгын ажлын үед хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулан технологийн дагуу доторлосон халхавчтай, зориулалтын сав байрлуулж, ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж үржихээс урьдчилан сэргийлж ариутгал хийж, хогийг хуримтлуулахгүйгээр зориулалтын цэгт тогтмол зайлуулна. | - | 2025 онд харуулын байрны барилгын ажлыг хийн гэж төлөвлөсөн байсан ч харуулын байрыг барилгын ажил хийгдэхгүй байдлаар шийдсэн. Тиймээс үйлдвэр орчмын бүсэд ямар нэгэн барилгын ажил хийгдээгүй болно. | 100 % |
| 4 | Аюултай хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлнэ. | 450.0 мян.төг | Аюултай хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлсэн. Үйл ажиллагааны явцад үүссэн химийн бодисын сав баглаа боодлыг “Элемент” ХХК-тай хийсэн гэрээний дагуу устгуулсан. | 100 % |
| | Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсийн гадна, түүнээс 60 м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулна. | - | Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсийн гадна, түүнээс 60 м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулсан. | 100 % |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Барилгын талбай, тоног төхөөрөмжийн засвар, зогсоолын талбай бусад газруудад хэрэглэсэн тос, цэвэрлэх материалыг хийх тусгай сав байрлуулна. | - | .Үйлдвэрийн талбайд хэрэглэсэн тос, цэвэрлэх материалыг хийх тусгай сав байрлуулсан. | 100 % |
| Нийт | | 5,200.0 | | |

Төслийн хэрэгжилтийн явцад үүссэн ахуйн хогийг хог хаягдлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу ангилан ялгаж, зориулалтын сав, талбайд түр хадгалсны дараа гэрээт байгууллагаар тогтмол ачуулж зайлуулсан. Ахуйн хог ачилтын ажлыг Налайх “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах “Хог хаягдлын төлбөрт үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний дагуу нийт 20 удаа ачуулсан байна. */Хог ачуулсан нэхэмжлэх болон төлбөр төлсөн баримтуудаас оруулав/.*


НЭХЭМЖЛЭХ №


НЭХЭМЖЛЭХ №


НЭХЭМЖЛЭХ №


НЭХЭМЖЛЭХ №







Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000002604663000251006000001370061
Борлуулагчийн:
ТТД: 2604663
НЭР: Налайхтохижилт үйлчилгээ
Хаяг: Монгол, Улаанбаатар, , , хуульч , 14
Утас: 22569, 22569, 88055504
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2025-09-30
Худалдан авагчийн:
ТТД: 6352901
Нэр: Электрокем монгол
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, , Ханну төв 500 тоот
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 9431 | | ш | 1 | 220,000 | 220,000 |

Бараа, ажил үйлчилгээний үнэ: 200,000
Нэмэгдсэн өртгийн албан татвар: 20,000
Нийслэл хотын албан татвар: 0
Нийт дүн: 220,000


ГОЛОМТ БАНК

Цахим гүйлгээний баримт

| | | | |
|---|---|---|---|
| 8125102557 | MN150005005749062084 | 605,000.00 MNT | Амжилттай |
| ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ | НАЛАЙХТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ | ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК-С ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУ | |
| | ХААН ТӨВ БАНК | 2025-07-08 | |

ГОЛОМТ БАНК ХҮЛЭЭН АВСАН

*Зураг 30. Үйлдвэрийн ахуйн хог ачуулсан нэхэмжлэх болон төлбөр төлсөн баримт*

Мөн үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүссэн ахуйн бохир усыг гэрээт байгууллагаар дамжуулан тогтмол соруулах, зайлуулах ажлыг тогтмол хийж байна. Бохир ус соруулах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 2025/02 дугаартай Данхаадай” ХХК-тай байгуулсан

гэрээний “Бохир ус зайлуулах үйлчилгээний гэрээ”-ний дагуу гүйцэтгэсэн. Гэрээний хүрээнд дараах ажлууд хийгдсэн.

- Үйлдвэрийн талбайд байрлах бохирын цооногоос бохир усыг тогтмол соруулсан
- Тайлант хугацаанд нийт 8 удаа, нийт 24 тн бохир усыг соруулсан байна.
- Бохир ус соруулах явцад алдагдах, асгарах, хөрс болон ус бохирдох зөрчил гараагүй.
- Үйлчилгээг бохир ус зайлуулах гэрээ болон төлбөрийн баримтаар баталгаажуулсан.



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

**ТӨЛБӨРИЙН БАРИМТ**

ДДТД: 000005325447000250905000001944274
**Борлуулагчийн:**
ТТД: 5325447
НЭР: Данхаадай
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 12-р хороо, 11, 50
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2025-09-05
**Худалдан авагчийн:**
ТТД: 6352901
Нэр: Электрокем монгол
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, , Ханну төв 500 тоот
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам бохир усыг ариутгах цэвэрлэх үйлчилгээ | 9411000 | ш | 1 | 800,000 | 800,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 727,272.73 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 72,727.27 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 800,000 |



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

**ТӨЛБӨРИЙН БАРИМТ**

ДДТД: 000005325447000250507000011321708
**Борлуулагчийн:**
ТТД: 5325447
НЭР: Данхаадай
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 12-р хороо, 11, 50
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2025-04-30
**Худалдан авагчийн:**
ТТД: 6352901
Нэр: Электрокем монгол
Хаяг: Монгол, Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, , Ханну төв 500 тоот
Утас:

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бохир усны шугам бохир усыг ариутгах цэвэрлэх үйлчилгээ | 9411000 | ш | 1 | 800,000 | 800,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 727,272.73 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 72,727.27 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 800,000 |

*Зураг 31. Ахуйн бохир ус соруулуулсан төлбөрийн баримт*



БАТЛАВ.ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
"......................." ХХК -ИЙН
ЗАХИРАЛ
гарын үсэг ....................
харилцах утас:

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ
" ДАНХААДАЙ ХХК " – ИЙН
ЗАХИРАЛ
М.ТӨМӨР
гарын үсэг ....................
харилцах утас:

**БОХИР УС СОРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2025 оны 04 - р сарын 16 № 202502 Улаанбаатар хот

**НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО**

1.1.Энэхүү гэрээг нэг талаас "Электрокем-Монгол" \ цаашид захиалагч гэх/ нөгөө талаас " ДАНХААДАЙ ХХК " \ цаашид гүйцэтгэгч гэх \ нар харилцан тохиролцож тус гэрээг байгуулав.

**ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Захиалагч тал гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулна.
2.2. Захиалагч тухайн бохир ус соруулан гүйцэтгүүлэх ажлын талаарх цаг хэмжээг тодорхойлж мэдээлнэ.
2.3. Төлбөрийг гэрээнд заасны дагуу дансаар хийнэ.
2.4. Дараагийн захиалагат ажлыг урьдчилан мэдээлнэ.

**ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Гүйцэтгэгч тал цаг ямагт машин техникийг бэлэн байлгана.
3.2. Гүйцэтгэгч ажлын явцад тухайн машинд эвдрэл, саатал гарсан тохиолдолд, хариуцлагыг өөрөө хүлээнэ.
3.3. Ажилд гарахын өмнө жолоочид явах маршрут, гүйцэтгэх ажлын тухай тодорхой заавар өгөх.
3.4. Захиалагчийн хүсэлтийн дагуу тухайн ажлыг чанартай хийж гүйцэтгэнэ.
3.6. Гүйцэтгэгч ажлаа хийх үедээ тус байгууллагын обьектод эвдрэл учруулбал бүрэн хариуцна.



**ДӨРӨВ. ТАЛУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

4.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.
4.2. Учирсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талд нөхөн төлнө.
4.3. Гэрээний талаар харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
4.4. Талуудын аль нэг тал нь гэрээгээ биелүүлээгүй тохиолдолд үл маргах журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдвэрлэж чадаагүй нөхцөлд Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
4.5. Талууд шаардлагатай гэж үзвэл, гэрээг аль нэг тал санал гаргаагүй тохиолдолд цаашид сунгаснаар тооцно.

**ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО**

5.1. Төлбөрийг ХААН БАНКНЫ 502 315 04 65 тоот дансанд шилжүүлнэ.
5.2. Бохир ус тээвэрлэх хөлсийг 600,000 төгрөгөөр тооцно.
5.3. Бохир ус соруулснаас гадна нэмэлт үйлчилгээний \ ёмкость цэвэрлэх, бөглөө гаргах, худаг угаах \ хөлсийг харилцан тохиролцож тооцно.

**ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

6.1. Энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хойш 6.2, 4.5 -д заасны дагуу хугацаанд хүчинтэй байна.
6.2. Гэрээ байгуулсан огноо: 2025 оны 04 – р сарын 16 -ны өдрөөс 2026 оны 04 - р сарын 16 -ны өдөр хүртэл хүчинтэй.
6.3. Гэрээг 1 жилийн хугацаатай хийв. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Захиалагчийг төлөөлж:
Гүйцэтгэгчийг төлөөлж:

*Зураг 32.Бохир ус соруулах гэрээ*

Үйл ажиллагааны явцад ашиглагдсан химийн бодисын хоосон сав, баглаа боодлыг аюултай хог хаягдалд хамааруулан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагын дагуу цуглуулж, түр хадгалсны дараа тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар дамжуулан устгуулсан.

Аюултай хог хаягдлыг хяналттайгаар хураан, хадгалсны дараа “Элемент” ХХК-тай байгуулсан 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн ХБ-25/073 дугаартай “Химийн хортой болон аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ”- ний дагуу хүлээлгэн өгч, устгуулсан.


БАТЛАВ:
“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Ө.ОДОНСҮРЭН/
ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ







АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ
ELEMENT LLC
2025 оны 06 сарын 24 өдөр
Актын дугаар: 25/180
Улаанбаатар хот
Аюултай хог хаягдал үүсгэгч: Электрокем монгол ХХК
Устгалд оруулсан аюултай хог хаягдлын жагсаалт

| № | Хаягдлын нэр, төрөл | Хэмжээ | Нэгж кг | Аюулын ангилал |
|---|---|---|---|---|
| 1 | Бодисын хоосон шуудай | 36.0 | кг | Хортой |
| | Нийт | 36.0 | кг | |

Устгасан аргачлал:
Дээрх 36.0 кг хортой хог хаягдлыг “Элемент” ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах комисс хүлээн авч зориулалтын шатаах зууханд 1200°С -т бүрэн шатааж хаягдал үнсийг ландфиллдэж устгав.
Жич: Устгалд орсон бодисын нэр торлийн жагсаалт хавсаргав.
Устгал хийсэн
Химийн мэргэжилтэн /Э.Халиун/
Акт хүлээн авсан


ELEMENT LLC
“Электрокем монгол” ХХК-наас 2025 оны 06 сарын 03-ны өдөр ирсэн аюултай хог хаягдал устгалд оруулж буй байдал. Устгалын актны хавсралт зураг.
Актын дугаар: 25/180
Химийн мэргэжилтэн Э. Халиун


АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

*Зураг 33.*
*Химийн бодисын сав баглаа, боодол устгуулсан баримт*

## 10. Орчны шинжилгээний хөтөлбөр -2025 он

*Хүснэгт 17. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| № | | Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Агаарын чанар | Хүхрийн исэл SO2 Нүүрстөрөгчийн дутуу исэл CO Азотын исэл NOx Тоос (SPM) Хар тугалга PB Бензапирен | 397.0 мян.төг | Агаарын чанарын шинжилгээг үйлдвэрийн дотор болон гадна агаараас 2025 оны 05 дугаар сарын 20 болон 09 дүгээр сарын 12 -нд “Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори”-оор хийлгэсэн. | 100% |
| 2 | Хөрсөн бүрхэвч | pH, ялзмагийн агууламж, ялзмагт давхаргын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, хүнд металууд, 1 см3 дэхь бактери, эмгэг төрүүлэгч бичил биетэн байгаа эсэх | 148 мян.төг | Хөрсний чанарын шинжилгээг 2025 оны 04 дүгээр сарын 25 -нд “Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори”-оор хийлгэсэн. | 100% |
| 3 | Усан орчин | Ca, Mg, Cl, SO4, NO2, K-ийн агууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулга, хүнд металлыг тодорхойлох | 200 мян.төг | Усны чанарын шинжилгээг 2025 оны 04 дүгээр сарын 25 -нд “Цаг уур орчны шинжилгээний газар, Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори” болон 09 дүгээр сарын 25-нд “Хими, хими технологийн хүрээлэн”-ээр хийлгэсэн. | 100% |
| Нийт | | | 745.0 | | 100% |

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны шинжилгээ, хяналт, мониторингийн хөтөлбөрийн дагуу үйлдвэрийн бүс орчмын агаар, ус, хөрсний чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлсэн.

Шинжилгээг **“Цаг уур, орчны шинжилгээний газар**, **Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори”** болон **“Хими, Хими технологийн хүрээлэн”**-гээр тус тус хийлгэсэн. Шинжилгээний ажлын хүрээнд дараах хэмжилтүүд хийгдсэн.

- **Агаарын чанар:** Үйлдвэрийн дотор болон гадна орчны агаараас дээж авч, **4 үзүүлэлтээр** (Азотын давхар исэл ($NO_2$), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), хүхрийн давхар исэл ($SO_2$) гэх мэт) шинжилгээ хийлгүүлсэн;
- **Усны чанар:** Усны дээжийг **18 үзүүлэлтээр** (жишээ нь:усны орчин, pH,фосфат, фтор, натри, хлор, нитрит, нитрат, гидрокарбонат хар тугалга, хүнд металл гэх мэт) шинжилгээ хийлгүүлсэн
- **Хөрсний чанар:** Хөрсний дээжийг **7 үзүүлэлтээр** (жишээ нь: кадьми, хар тугалга, мөнгөн ус, хром, цайр, зэс, стронци гэх мэт) шинжилгээнд хамруулсан.

Шинжилгээний үр дүнгээс харахад агаар, ус, хөрсний чанар нь холбогдох стандартад нийцсэн, бохирдлын түвшин зөвшөөрөгдөх хэмжээнд байсан. Иймээс үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр орчны бохирдол, сөрөг нөлөөлөл илрээгүй.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

СОРИЛТЫН ДҮН



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

СОРИЛТЫН ДҮН



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
/TEST REPORTS OF ACCREDITED LABORATORY/



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

СОРИЛТЫН ДҮН



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/114
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас : "Электрокем Монголиа" ХХК
Сорьц авсан хүний нэр,албан тушаал : Б.Батбаатар
Сорьцын тоо,төрөл : 1 хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2025.04.25
Сорьцын тодорхойлолт : Налайх дүүрэг 3-р хороо аж үйлдвэрийн парк
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2025.04.30
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Яндангийн хажуу 6 метр | <0.05 | 20 | <0.005 | <0.5 | 125 | 26 | 289 |
| | MNS 5850:2019/ ЗДХ/ | 3 | 100 | 2 | 150 | 300 | 100 | 800 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Ахлах шинжээч Б.Даваасүрэн
Хянаж баталгаажуулсан: БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

*Зураг 34. Агаар, ус, хөрсний шинжилгээний үр дүн*

## 11.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

*Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт*

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | Хэмжих нэгж, Тоо хэмжээ | Хэрэгжилт | Биелэлт % |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах | 200.0 мян.төг | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулсан. | 100% |
| 2 | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг даргад танилцуулах | 200.0 мян.төг | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг даргад танилцуулсан. | 100% |
| 3 | Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн нөлөөллийн бүсэд оршин суугчдад | 200.0 мян.төг | Нутгийн оршин суугчдад танилцуулсан. | 100% |
| Нийт | | 600.0 мян.төг | | 100% |

## 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн зардлын нэгдсэн дүн

Улаанбаатар хотын Налайх дүүрэг, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийг түшиглэн байгуулах “Хар тугалгат - хүчлийн батарейг байгаль орчинд ээлтэй технологиор боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх төсөл”-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтинд зарцуулсан нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

*хүснэгт 19. Зардлын нэгдсэн дүн*

| | Үзүүлэлт | **Хэмжих нэгж** | **Нийт зардал /мян.төн/** |
|---|---|---|---|
| 1. | Удирдлага зохион байгуулалт | **мян.төг** | 24054.0 |
| 2. | Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө | **мян.төг** | 13,300.0 |
| 3. | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | **мян.төг** | 6,000.0 |
| 4. | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө. | **мян.төг** | 4,900.0 |
| 5. | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | **мян.төг** | - |
| 6. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр. 2025 он. | **мян.төг** | 745.0 |
| 7. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө. 2025 он | **мян.төг** | 600.0 |
| 8. | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан дүн | **мян.төг** | 7,000.0 |

| | | |
|---|---|---|
| **БҮГД ДҮН** | | **56599.0** |

## Хяналт шалгалт хийгдсэн талаар:

“Электрокем Монгол” ХХК-ийн Ашиглалтаас гарсан хар тугалган батарейг дахин боловсруулах үйлдвэрт хийсэн 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр “НБОГ-ын хяналтын хэлтсийн даргын баталсан 2025 оны 04 -р сарын 14-ний 13/20 дугаартай төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд ажлын хэсэг шалгалт хийсэн.

Хяналт шалгалтаар үйлдвэрийн доторх гүний худгийн усыг зохих гэрээ зөвшөөрөлгүйгээр ашигласан гэсэн зөрчил илэрсэн. Уг зөрчил нь тухайн үед худгийн пасспорт дээр бичилт хийхэд алдаа гарч, гүний худгийн координатыг буруу бичсэнээс үүссэн. Энэ нөхцөл байдлыг Нийслэлийн байгаль орчны газрын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хийгдсэн төлөвлөгөөт бус шалгалтаар мэдсэн бөгөөд үйлдвэрийн доторх худагт шинээр худаг гаргах зөвшөөрөл авах, худгийн пасспортыг баталгаажуулах, ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулан, ус ашиглах гэрээ дүгнэлт гаргуулах, ус ашигласны төлбөрийг холбогдох татварын дансанд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан зөрчлийг арилгахаар ажиллаж байна.

Зөрчлийг арилгах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

- Зөрчилд ноогдуулсан торгуулийг төлсөн.
- Худаг гаргах зөвшөөрлийг “Нийслэлийн байгалт орчны газар” – аас авсан.
- Худгийн пасспортыг баталгаажуулсан.
- Усны газарт боломжилт нөөцийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг өгсөн байна.



ГОЛОМТ БАНК
Сайн сайхны санхүүжүүлэгч

**Цахим гүйлгээний баримт**

Хүсэлтийн лавлах дугаар: S53076426202509163 — Татсан огноо: 2025-10-31 11:30

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 8125102557<br>MN540015008125102557 | MN980090100200000906 | 5,000,000.00 MNT | Амжилттай |
| Шилжүүлэгчийн нэр: ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ | Хүлээн авагчийн нэр: НБОГ.ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГО | Гүйлгээний утга: ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК-С ТОРГУУЛИЙН ТӨЛБӨ | |
| | Хүлээн авагчийн банк: Төрийн сан | Гүйлгээний огноо: 2025-09-16 | |



*Зураг 35. Усны торгууль төлсөн баримт*

Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яамны харьяа салбарын газраас 2025 оны 04 дүгээр сарын 31 – ний өдөр төлөвлөгөөт үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт

шалгалт хийсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай албан даалгавар өгсөн. Албан даалгаврыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн хэрэгжүүлсэн тайланг "Нийслэлийн байгаль орчны газар"-т хүргүүлсэн.

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

**Цахим гүйлгээний баримт**

Хүсэлтийн лавлах дугаар: 343287307 — Татсан огноо: 2025-06-02 14:14

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8125102557**<br>MN540015008125102557 | **100200000906** | **2,000,000.00 MNT** | **Амжилттай** |

| Шилжүүлэгчийн нэр | Хүлээн авагчийн нэр | Гүйлгээний утга |
|---|---|---|
| **ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ** | **НБОГ.ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГО** | **Электрокем Монгол ХХК-с 6352901** |
| | Хүлээн авагчийн банк<br>**Төрийн сан** | Гүйлгээний огноо<br>**2025-06-02** |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| **г. болормаа** | | ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН |

*Зураг 36. Торгууль төлсөн баримт*

## Хавсралт

1. *Аж ахуйн нэгжид газар ашиглуулах гэрээ*

**БАТЛАВ:**

"НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГАЗРЫН ДАРГА
С.БАТЖАРГАЛ

"ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ө.ОДОНСҮРЭН

АЖ АХУЙН НЭГЖИД ГАЗАР АШИГЛУУЛАХ
ГЭРЭЭ

2023 оны 12 сарын 01 өдөр | Дугаар 2023/29 | Налайх дүүрэг

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, Засгийн газрын тогтоол, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэлийн засаг даргын захирамж зэргийг үндэслэн газар эзэмшигчийг (Гэрчилгээний №000439224) төлөөлж Инженер Б.Батбилэг, нөгөө талаас улсын бүртгэлийн **9011756132** тоот гэрчилгээ, **6352901** тоот регистрийн дугаартай **"Электрокем монгол"** ХХК-г төлөөлж Гүйцэтгэх захирал **Ө.Одонсүрэн** нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болох дараахи зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

1.1. Газрын байршил, хэмжээ, хил заагийг тодорхой харуулсан кадастрын зураг.
1.2. Газар эзэмшигчээс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт.
1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт.
1.4. Үйлдвэрлэлийн зориулалт, нотлох бичиг баримтууд.

**Хоёр: Гэрээний нөхцөл**

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ **4.0933** га бөгөөд **Хар тугалгат хүхрийн хүчлийн батерэйг байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх** үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглана.

2.2. Газрын төлбөрийн хэмжээ: Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, 2003 оны УИХ-ын 54-р тогтоолын 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтыг барина. Үүнээс:

| | |
|---|---|
| 1-р улиралд 0.0 төг | 2-р улиралд 0.0 төг |
| 3-р улиралд 0.0 төг | 4-р улиралд 0.0 төг |

Дөрөв. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

4.1. Паркийн нэгж нь дараах үйл ажиллагаар эрхэлнэ:

A. Паркийн нэгж нь техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшингийн үнэлгээ, холбогдох байгууллагаар гаргуулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн гэрээ байгуулах эрх үүснэ.
B. Үйлдвэрлэл технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу паркт хориглох үйл ажиллагаар зэрчээгүй байх.
C. **Хар тугалгат хүхрийн хүчлийн батерэйг байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх үйлдвэрлэлийн** үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаар дур мэдэн явуулахгүй байх.
D. Гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн 4, 7, 10, 1 дугээр сард паркийн захиргаанд гарган өгнө.
E. Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт эдлэх, дэд бүтцээр хангуулах эрхээ хэрэгжүүлэхийг паркийн удирдлагаас шаардах.
F. Жил бүр байгаль орчны менежментийн төлбөрөө байршуулах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх.
G. Шинэ технологи нэвтрүүлэх, шинээр үйлдвэр байгуулахад төрөөс санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл хүсэх.
H. Орчны эко системийг бүрдүүлэх зорилгоор жил бүр ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх үүрэгтэй.
I. Үйлдвэрлэл технологийн паркийн захиргаанаас нэгдсэн байдлаар зохион байгуулсан арга хэмжээ, нийтээр дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх.
J. Ус, дулаан, цахилгааны хэрэглээний төлбөр болон хог хаягдлын төлбөрийг заасан хугацаанд төлөх.
K. Хүний нөөцийн 80 хувиас доошгүй хэсгийг орон нутгаас хангах ба ажилчдыг гадаад дотоодын мэргэшүүлэх сургалтанд хамруулах хүний нөөцийн хөгжлийн бодлоготой байх.
L. Паркийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан байх.
M. Тухай орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгж болсон байх.
N. Зам, ус, дулаан, цахилгаан ашигласны төлбөрийг сар бүрийн эхний 10 хоногт багтаан төлөх.
O. Үйлдвэрийн бүтээн байгуулалтыг 1 жилийн хугацаанд эхлүүлээгүй, үйлдвэрлэлийг 2 жилийн хугацаанд эхлүүлээгүй бол гэрээг цуцална.

4.2. Паркийн захиргаанаас ашиглахаар авсан **4.0933 га** газрыг ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажуулах, гэрээний 4.1.C хэсэгт заасан чиглэлийг өөрчлөхгүйгээр үйл ажиллагаа хэвийн явуулах.

4.3. Паркийн нэгж нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

4.4. Паркийн нэгжийн удирдлага нь гэрээний биелэлт болон үйл ажиллагааны явцын тухай мэдээллийг паркийн удирдлагад энэхүү гэрээний 3.4-т заасан хугацаанд гаргаж өгч, жил бүрийн эцэст хоёр тал хамтран дүгнэнэ.

4.5. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангуулах, холбогдох хуульд заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлнэ.

Тав. Маргаан таслах

5.1. Гэрээний хэрэгжилтийн явцад гарч болзошгүй аливаа маргаантай асуудлыг талуудын хоорондын харилцан зөвшилцөл, тохиролцоогоор шийдвэрлэнэ.

5.2. Газар эзэмших, ашиглах эрх болон гэрээний хугацаа дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай " Газрын тухай хууль"-ийн 47-р зүйлийг баримтлана.

5.3. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл:

- Паркийн нэгж нь цэвэр усны хэрэгцээнд зориулсан савыг суурилуулж бэлтгэсэн байх,
- Зориулалтын бие засах газрыг бохирын савны хамтаар шийдсэн байх,
- Цахилгааны хэрэглээг тусгаарлахын тулд стандартад нийцсэн, үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээнд тохирсон тоолуурыг тавиулж паркийн удирдлагад мэдэгдэх,
- Талууд харилцан тохиролцож менежментийн нийт зардлыг тооцоолно./зүлэгжүүлэлт, зам талбайн арчлалт, зар сурталчилгаа, харуул хамгаалалт, хог тээвэр г.м/

**Зургаа. Бусад зүйл**

6.1. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 /тав/ жилийн хугацаатай байгуулав.

6.2. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГАЗРЫН ИНЖЕНЕР

Б.БАТБИЛЭГ

ХАЯГ: НАЛАЙХ ДҮҮРЭГ 3-Р ХОРОО

УТАС: 7575-1001

"ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ө.ОДОНСҮРЭН

ХАЯГ: УБ ХОТ, БГД, 2-Р ХОРОО, ХАННУ ТӨВ 500 ТООТ

УТАС: 77229999, 99114175

*2. Паркийн нэгж болох паркт үйл ажиллагаа явуулах гэрээ*

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН НЭГЖ БОЛОХ "ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК-ИЙН ПАРКТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ГЭРЭЭ

20*23* он *12* сар *01* өдөр — Дугаар *23/29* — Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон тусгай зөвшөөрөл эзэмшигч паркийн удирдлагын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

1.2. Налайх дүүрэгт паркийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан паркийн удирдлагыг төлөөлж нэг талаас **Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-ын дарга С.Батжаргал**, нөгөө талаас **"ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК** паркт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг төлөөлж Гүйцэтгэх захирал **Ө.ОДОНСҮРЭН** нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Үйлдвэрлэл, технологийн паркт тухайн нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл, орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг үндэслэн үйл ажиллагаа эрхлэх гэрээний хугацаа эхний ээлжинд **5 жил** байна.

2.2. Гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж, техник, эдийн засгийн үндэслэлийг хэрэгжүүлэх зорилгоор паркийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр гэрээнд заасан үүргээ гүйцэтгэж байгааг харгалзан гэрээний хугацааг 5 хүртэл жил сунгаж болно.

Гурав. Паркийн удирдлагын эрх, үүрэг

3.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2.2, Засгийн газраас баталсан "Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам"-д заасан нөхцөлийг бүрэн хангаж ажиллана.

3.2. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

3.3. Паркт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана.

3.4. Гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн 4, 7, 10, 1 дүгээр сард паркт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж бүрээр гаргуулан авч дүгнэнэ.

3.5. Паркийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан журам, заавар, Монгол Улсын болон олон улсын стандартыг мөрдөн ажиллана.

3.6. Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байгаа аж ахуйн нэгжийн гэрээг цуцлах асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлүүлнэ.

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар ашиглуулагчийн ____________________________ тоот дансанд шилжүүлж байна.

*/Банкны салбарын нэр, дансны дугаар/*

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

**Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг**

3.1. Гэрээний нөхцлийн дагуу газрыг ашиглагч байна.

3.2. Газар эзэмшигчээс газрын төлөв байдал, чанарын улсын хяналт баталгааг гаргуулж авах.

3.3. Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол гэрээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар гэрээний хугацааг сунгуулах.

3.4. Газар эзэмшигчээс газрын асуудалтай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх.

3.5. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

**Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх үүрэг**

4.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах.

4.2. Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараахи шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй.

Үүнд:

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх.

- Газрын хэвлийн зориулалтын бусаар хөндөх.

- Үйлдвэрлэлийн зориулалтыг өөрчлөх.

4.3. "Газрын тухай хууль" –ийн 35.3.1-35.3.6 –д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах.

4.4. Газар ашиглуулах гэрээг жил бүр дүгнэх.

4.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

**Тав. Газрын талаархи эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт**

5.1. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрхи үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл паркийн удирдлагатай зөвшилцсөнөөр гэрээг шинэчлэх, шийдвэрлэнэ.

5.2. Хэрэв маргаантай асуудлыг талууд энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүх, эсхүл Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилсэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй болно.

6.3. Гэрээний оролцогч талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд гэрээний салшгүй хэсэг болно.

6.4. Эх хувьд баллаж засварласан болон бусад аргаар оруулсан аливаа нэмэлт бичиг хүчингүйд тооцно.

6.5. Талуудын удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.

6.6. Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ-ЫН ДАРГА

С.БАТЖАРГАЛ

ПАРКИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖ "ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ө.ОДОНСҮРЭН

Утас:77229999, 99114175

--------oOo--------

3. *Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөл, /0000033 дугаартай 5 жилийн хугацаатай/*

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000033 Олгосон: 2024.04.25

Хавсралт 1 -д заасан шаардлагын дагуу аюултай хог хаягдал Хаягдал аккумлятор дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 9011756132 улсын бүртгэлийн дугаартай 6352501 регистрийн дугаартай Электрокем монгол ХХК -д 2024 оны 04 дугаар сарын 25 -ны өдрөөс 2029 оны 04 дугаар сарын 25 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000025

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар хот аймаг, хот Баянгол сум, дүүргийн 2-р дугаар баг, хорооны Ханну төв, 500 тоот

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар аймаг, хот Налайх сум, дүүргийн 3-р дугаар баг, хорооны

**Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.**

**Зөвшөөрөл олгосон:**

| | | |
|---|---|---|
| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | Б.Ба | Б.БАТ-ЭРДЭНЭ |
| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |

4. *Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, / 0002614 дугаартай 5 жилийн хугацаатай/*

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2024.01.10 Дугаар: 0002614 Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ ХХК
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9011756132
Регистрийн дугаар: 6352901
Хаяг: Улаанбаатар, Баянгол, 2-р хороо, Хануу тав, 500 тоот

Утас: 77229999
Дараах химийн хортой, аюултай бодис:
Импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг
2024.01.10-2029.01.10 хүртэл хугацаагаар олгов.

| № | Бодисын нэр | | Томъёо | Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/ | Ангилал | Гэмтээгчийн код | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол | Олон улсын | | | | | |
| 1 | Натрийн карбонат | Sodium carbonate | $Na_2CO_3$ | 497-19-8 | | | 760 тн |
| 2 | Натрийн шүлт | Sodium hydroxide | NaOH | 1310-73-2 | | | 50 тн |
| 3 | Натрийн нитрат | Sodium nitrate | $NaNO_3$ | 7631-99-4 | | | 30 тн |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | | | | | | | |

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Бичигт, Баянхошуу, Гашуунсухайт, Чингис хаан

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга / албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.ЦОГТГЭРЭЛ /

Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ц.БАТЖАРГАЛ /

5. *Төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл*

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2025.09.23

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл**

Регистрийн дугаар : **6352901**
Нэр : **ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ Хязгаарлагдмал хариуцлагатай компани**

**Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл**

Авсан огноо : **2022-07-04**
Дуусах огноо : **2028-09-19**
Хүчинтэй эсэх : **Хүчинтэй**
Тусгай зөвшөөрлийн нэр : **ТӨМӨРЛӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

*Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байнгын шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгуурууд хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу*

*6. Байгаль орчны аудитын гэрээ*

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2025 оны 09 дүгээр
сарын 23-ний өдөр | № ASH-25/01 | Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид **"Гэрээ"** гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлүүд, мөн хуулийн холбогдох нийтлэг зохицуулалтуудад үндэслэн,

**Нэг талаас** Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан **"Алтан шанага"** ХХК /РД: 5649544/, (цаашид **"Гүйцэтгэгч"** гэх)

**Нөгөө талаас** Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "**Электрокем Монгол**" ХХК /РД: 6352901/ (цаашид **"Захиалагч"** гэх)

*(Дээр дурдсаныг тус тусад нь **"Тал"** хамтад нь **"Талууд"** гэх)* нар доорх нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

1.1.Энэхүү гэрээ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/809 дүгээр тушаалын 1-р хавсралтын 4.4 -ийг удирдлага болгосон ба "Электрокем Монгол" ХХК -ийн Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрлэл, технологийн паркид "Ашиглалтаас гарсан хар тугалгын батарейг байгаль орчинд ээлтэй технологиор дахин боловсруулах" үйлдвэрт байгаль орчны төлөвлөгөөт аудит хийх ажлыг энэхүү гэрээний дагуу талуудын хооронд хамтран холбогдох эрх үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Ерөнхий нөхцөл**

2.1. Захиалагч нь Байгаль орчны багц хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актууд, Байгаль хамгаалах тухай хуулийн 10.1 дэх заалтыг үндэслэн Байгаль орчны аудит хийлгэхээр энэхүү гэрээг байгуулж байна.

2.2. Гүйцэтгэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.3 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчны аудитыг гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулж байна.

2.3. Талууд нь байгаль орчинд учруулж болох аливаа сөрөг нөлөө, хохирол, үр дагаварыг арилгах арга хэмжээ авах, захиалагчийн экологи, эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, улмаар байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад туслах, дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг учирч болох хохирол, эрсдэл, алдагдалаас урьдчилан сэргийлэх зорилготойгоор байгаль орчны аудит хийхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулж байна.

2.4. Байгаль орчны аудитыг гэрээ батлагдаж, урьдчилгаа төлбөр шилжсэн өдрөөс хойш хуанлын 45 /дөчин таван/ хоногийн дотор хийж гүйцэтгэнэ.

2.5. Гүйцэтгэгч нь Ажлыг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш тус гэрээний хавсралтад /хавсралт 2/ өгөгдсөн хугацааны хуваарийн дагуу бүрэн гүйцэтгэж БОА-ын тайланг Захиалагч талд актаар хүлээлгэн өгнө.

2.6. Гэрээний хавсралт 2-д заасан захиалагч талын хариуцах хугацаа гэрээт хугацаанаас хэтэрсэн тохиолдолд Гүйцэтгэгч талын хариуцсан хугацаа харилцан сунгагдана.

2.7. Гэрээний хавсралт 1-ийн 3.3-т заагдсан хугацаанд багтаж Захиалагч тал холбогдох материалыг танилцуулах боломжгүй тохиолдолд Захиалагч талын хариуцах хугацааг 1 удаа ажлын 5 хоногоор сунгана.

2.8. Гэрээний 2.7-д заасан хугацаанд багтаж Захиалагч тал аудитын ажил эцэслэн боловсруулахад шаардлагатай материалыг бүрэн танилцуулах боломжгүй тохиолдолд тухайн материалтай холбогдол бүхий байгаль орчны асуудал аудитын ажлын хязгаарлалтад хамаарна.

2.9. Гүйцэтгэгч тал тус аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх хуваарийг захиалагч талд хүлээлгэн өгч, тус байгууллага актаар хүлээн авснаар энэхүү гэрээ дуусгавар болно.

2.10. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

2.11. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

2.12. Байгаль орчны аудит хийх төлөвлөгөөг харилцан тохиролцож боловсруулна.

2.8. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/809 дүгээр тушаалын 2-р хавсралтын заасан арга зүйн дагуу хийж гүйцэтгэх

2.9. Аудитын тайлан бол аудитын үйлчлүүлэгчдийн өмч мөн. Аудитын багийн гишүүд тайлангийн нууцлалыг чандлан хадгална.

**Гурав. Гэрээний үнэ**

3.1. Ажлын нийт хөлс: 8,000,000 (Найман сая) төгрөг байна. Энэхүү гэрээний үнийн дүнд НӨАТ татвар, хураамж орсон болно.

3.2. Гэрээний 3.1 дэх хэсэгт заасан төлбөрийн 60 хувь буюу 4,800,000 (Дөрвөн сая найман зуун мянган) төгрөгийг гэрээ батлагдсаны дараа гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

3.3. Гэрээний үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэгч тал ажлыг бүрэн гүйцэт дуусгаж, хүлээлгэн өгч акт үйлдсэний дараа Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

3.4. Захиалагч тал гэрээний ажлын хөлсийг саатуулсан тохиолдолд үлдэгдэл төлбөрөөс тооцон хоногийн 0.1 хувийн алданги төлнө.

**Дөрөв. Захиалагчийн эрх ба үүрэг**

4.1. Гүйцэтгэгчийг үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй

4.2. Байгаль орчны аудит хийхэд шаардагдах байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, хөтөлбөрийн хэрэгжилт, дотоод аудитын тайлан, төлбөрийн баримтууд, өмнөх аудитын тайлан, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг ажил гүйцэтгэгчийн мэдэлд шилжүүлнэ.

4.3. Захиалагч тал нь Гүйцэтгэгч талаас гэрээний дагуу хугацаандаа дуусгахыг шаардах эрхтэй.

4.4. Захиалагч тал нь гүйцэтгэсэн ажлыг ажлын комисс гарган актаар хүлээн авна.

4.5. Захиалагч тал нь гүйцэтгэсэн ажлын хөлсийг хугацаанд нь төлж барагдуулах.

4.6. Захиалагч нь байгаль орчны аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Нийслэлийн Байгаль орчны газарт зөвлөмжийн хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

**Тав. Гүйцэтгэгчийн эрх ба үүрэг**

5.1. Гүйцэтгэгч нь байгаль орчины аудит хийлгэхээр захиалагчаас ирүүлсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудит хийлгэх хугацааны хяналт шинжилгээний хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилт, дотоод аудитын тайлан, төлбөрийн баримтуудын бүрэн бүтэн байдлыг хариуцна.

5.2. Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд, батлагдсан төлөвлөгөөний дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

5.3. Гэрээний Хавсралт №1-д заасан ажлыг төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд ажлыг биечлэн гүйцэтгэнэ.

5.4. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

**Зургаа. Онцгой нөхцөл**

6.1. Гэрээний хугацаанд аудитын ажил гүйцэтгэх үед давагдашгүй хүчин зүйл газар хөдлөлт үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо зэрэг нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хугацааг сунгах үндэслэл болно.

6.2.Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн газрын төрийн захиргааны байгууллагаас авна.

6.3.Гэрээг байгуулсанаас хойш талууд энэхүү гэрээтэй холбоотой хоорондоо солилцсон мэдээ мэдээлэл хүлээн авсан түүний нууцад тооцогдох мэдээллийг бусад үйлдвэр, байгууллагад, хүмүүст зарлан тараахгүй бөгөөд энэ гэрээнд дурьдсан зорилтоос өөрөөр хувьдаа ашиг олохын тулд ашиглахгүй.

6.4.Гүйцэтгэгч тал Захиалагчийн нууцыг өөрийн компанийн нууцын нэгэн адил задруулах, бусдад ашиглуулахаас зайлсхийн өндөр хариуцлагатай, сонор сэрэмжтэй хамгаална.

6.5.Харилцан шилжүүлэн өгсөн бөгөөд бичгээр үйлдсэн мэдээллийг байгаль орчны тайланд хавсаргана.

**Долоо. Хүлээх хариуцлага**

7.1.Захиалагч гүйцэтгэгчийг байгаль орчны аудит хийх баримт бичиг гаргаж өгөх, газар дээр нь үзлэг шинжилгээ хийх нөхцөлөөр бүрэн хангах үүрэгтэй.

7.2.Гүйцэтгэгч байгаль орчны аудитын тайлан, дүн мэдээний үнэн зөв байдлыг хариуцна.

7.3.Гүйцэтгэгч нь байгаль орчины аудитыг холбогдох арга, аргачлалын дагуу хийх үүрэгтэй.

7.4.Аудитын зөвлөмжөөр өгөгдсөн үүргийг захиалагч биелүүлэх үүрэгтэй.

7.5.Захиалагч байгаль орчны дүгнэлт, зөвлөмжид заасан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн талаархи тайлангаа хуулийн хугацаанд холбогдох байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

7.6.Гүйцэтгэгч нь байгаль орчины аудитыг холбогдох арга, аргачлалын дагуу гүйцэтгээгүйн улмаас байгаль орчинд учирсан аливаа хохирол, эрсдэлийг хуулийн өмнө хариуцах үүрэг хүлээнэ.

7.7.Захиалагч байгаль орчны аудитын дүгнэлт, зөвлөмжид заасан үл нийцлүүдийг зөвлөмжид заасан хугацаанд нь хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх аливаа хохирол, эрсдэлийг хуулийн

өмнө хариуцах үүрэг хүлээнэ.

7.8.Маргаан үүсэн тохиолдолд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв зөвшилцөлд эс хүрч чадвал Захиалагч талын оршин суугаа газрын иргэний шүүхээр маргаанаа шийдвэрлүүлнэ.

7.9. Гүйцэтгэгч тал энэхүү гэрээнд заасан үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувийн алдангийг Захиалагч талд төлнө.

**Найм. Давагдашгүй хүчин зүйл**

8.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, хил гааль хаалттай байх, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болох бөгөөд уг байдлын талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэж харилцан зөвшилцөлд хүрнэ.

8.2. Төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн гэрчилгээ нь давагдашгүй хүчин зүйл байсан, мөн үргэлжилсэн хугацааны хангалттай нотолгоо болно.

**Ес.Маргаан шийдвэрлэх**

9.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

9.2 Талууд харилцан тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүх, арбитрын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

**Арав. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам**

10.1. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь талуудын зөвшилцөлийн үндсэн дээр зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Уг нэмэлт өөрчлөлт гэрээний салшгүй нэгэн хэсэг болох бөгөөд хуулийн хүчин төгөлдөр байна.

**Арван нэг. Бусад заалт**

11.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж Гүйцэтгэгч тал ажлыг гүйцэтгэж дуусч, төлбөр тооцоо дууссанаар дуусгавар болно.

11.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр хоёр тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

11.3.Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлхийг хориглоно.

11.4. Аудитын явцад гүйцэтгэгч талд танилцуулж буй аудиттай холбоотой баримт бичгүүдийг эх хувиар танилцуулах боломжгүй тохиолдолд хуулбар хувийн үнэн бодит байдлыг захиалагч тал хариуцна.

11.5. Хуулбар хувиар аудит гүйцэтгэгч талд танилцуулсан баримт бичгүүд болон нэгдсэн дүнгээр танилцуулсан төлбөрийн баримтад илэрсэн аливаа зөрчил, үүнтэй холбогдон үүсэх хохирлыг гүйцэтгэгч тал үл хариуцна.

11.4. Энэхүү гэрээг 2 /хоёр/ хувь үйлдэнэ. Хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй байна

**Гэрээ байгуулсан талуудын мэдээлэл:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
**"ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК**
Утас, факс: 99114175
РД: 6352901 , УБД:9011756132
И-мэйл/Веб хуудас:
Electrochemmongolia@gmail.com

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
БГДүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж,
Ханну төв, 2 давхар, 203 тоот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ө.ОДОНСҮРЭН

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
**"АЛТАН ШАНАГА" ХХК**
Утас, факс 91117534
РД:5649544, УБД:9011377082

Дансны дугаар:1410008374 /төгрөг/
Банкны нэр: Голомт Банк
И-мэйл/Веб хуудас:
altanshanaga@gmail.com
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
СБДүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, 3,70,
"Хүдэрмөнх" ХХК-ийн байр 5 давхар 506 тоот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ГАНТӨМӨР

АЛТАН ШАНАГА ХХК
УЛААНБААТАР ХОТ

.............................. тоот гэрээний Хавсралт №

Энэхүү хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

## ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУВААРЬ

| Үе шат | № | Гүйцэтгэх ажлууд | Хугацаа | Хариуцах тал |
|---|---|---|---|---|
| 1-р үе шат | 1.1. | Аудитыг албан ёсоор эхэлсэнд тооцох | Урьдчилгаа төлбөрийг захиалагчийн дансанд шилжүүлсэн өдөр | Захиалагч/Гүйцэтгэгч |
| | 1.2. | Аудит шалгах хуудас бэлтгэхэд шаардлагатай ерөнхий материалуудыг жагсаалтын дагуу гаргаж өгөх | 3 хоног | Захиалагч |
| | 1.3. | Оффис дээрхи баримт бичгийн үзлэг хийх | 1 хоног | Гүйцэтгэгч |
| | 1.4. | Аудитын шалгуур хуудас бэлтгэж, төлөвлөгөөг гаргах | 7 хоног | Гүйцэтгэгч |
| | 1.5. | Аудитын төлөвлөгөөг танилцуулах | 1 хоног | Захиалагч/Гүйцэтгэгч |
| | 1.6. | Шалгуур хуудсыг боловсруулсаны дараа бүрдүүлсэн нэмэлт материалыг жагсаалтын дагуу гаргаж өгөх | 5 хоног | Захиалагч |
| 2-р үе шат | 2.1 | Үйл ажиллагааны явцтай газар дээр нь танилцах | 2 хоног | Гүйцэтгэгч |
| | 2.2 | Шалгуур үзүүлэлтээр тодорхойлж гаргасан нэмэлт материалуудтай танилцах | 1 хоног | Гүйцэтгэгч |
| 3-р үе шат | 3.1 | Аудитын тайланг боловсруулж урьдчилсан үр дүнг гаргах | 14 хоног | Гүйцэтгэгч |
| | 3.2 | Аудитын урьдчилсан үр дүнг танилцуулж санал авах | 3 хоног | Захиалагч |
| | 3.3 | Саналын дагуу тайланд нэмэлт оруулахад шаардлагатай материалыг гаргаж өгөх | 2 хоног | Захиалагч |
| 4-р үе шат | 4.1 | Аудитын тайлан эцэслэн боловсруулж хүлээлгэн өгөх, ажил хүлээлцэх акт үйлдэх | 5 хоног | Гүйцэтгэгч |
| | 4.2 | Аудитын зөвлөмж, дүгнэлтийн хамт холбогдох байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх | 1 хоног | Гүйцэтгэгч |

**Аудитын ажил гүйцэтгэх нийт хугацаа – Хуанлын 45 хоног**

Захиалагч талын төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Ө.ОДОНСҮРЭН

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

Гүйцэтгэх Захирал

Д.ГАНТӨМӨР

*7. Галын аюулгүй байдлын дүгнэлт*


ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ДҮГНЭЛТ

Дугаар 0034741

*8. Элемент гэрээ*

БАТЛАВ:
"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Б.ЭНХБАДРАЛ/

БАТЛАВ:
"ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Ө.ОДОНСҮРЭН/

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-25/04д

2025 оны 04-р сарын 16-ны өдөр — Улаанбаатар хот

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Нэг талаас **"Элемент"** ХХК РД: /2100061/ /цаашид **"Гүйцэтгэгч"** гэх/ түүнийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун, нөгөө талаас /цаашид **"Захиалагч"** гэх/-ыг **"Электрокем монгол"** ХХК РД:/6352901/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Ө.Одонсүрэн нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг өөрийн хими технологийн үйлдвэрлүү ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.2. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

1.2.1 Устгал хийх хог хаягдлын мэдээлэл, үнэ /Хавсралт №1/
1.2.2 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг
1.2.3 Захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
1.2.4 "Элемент" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

**ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ**

2.1. Захиалагч дараах эрхтэй:
2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.
2.2. Захиалагч дараах үүрэгтэй:
2.2.1 Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,
2.2.1. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу төсөг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,
2.2.2. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,
2.2.3. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,
2.2.4. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,
2.2.5. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

2.2.6. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.7. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог хаягдал ачилт хийж өгөх.

2.2.8. Аюултай хог хаягдлаа гэрээний хүчинтэй хугацаанд багтаан 4.3-т заасны дагуу хүлээлгэн өгч устгуулах.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хэлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, "аюултай" гэсэн тэмдэглэгээтэй байхыг шаардах, хаягүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичигүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд тулгуурлан тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдээлэл өгч зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

3.2.8. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг

## ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

